



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>2-5</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>6-44</i>
<hr/>	
<i>1.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээлэл сонсох</i>	<i>6-24</i>
<i>2.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/</i>	<i>24-25</i>
<i>3.Аймаг дундын отрын бүс нутаг болон бэлчээрийн ашиглалт, хамгаалалты талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох</i>	<i>25-35</i>
<i>4.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох</i>	<i>35-44</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны
06 дугаар сарын 06-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Б.Саранчимэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 02 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Б.Бейсен, Г.Ганболд, О.Цогтгэрэл, Ц.Цэрэнпунцаг;
Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аубакир, Т.Энхтүвшин;
Тасалсан: Ц.Анандбазар, Ж.Батжаргал, Г.Тэмүүлэн.

Нэг.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Болдбаатар, мөн газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн дарга Д.Сайханжаргал, мөн хэлтсийн мэргэжилтэн Д.Мөнхзул нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун, Ц.Идэрбат, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Болдбаатар, мөн газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн дарга Д.Сайханжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун, Ц.Идэрбат нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Байгаль

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Тогтоолын төслийг Байнгын хорооны дарга Б.Саранчимэг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Саранчимэг: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 5
Бүгд: 10
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Б.Саранчимэг: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжэе гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Б.Саранчимэг: “Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 06 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 13 минутад хэлэлцэж дуусав.

Гурав. Аймаг дундын отрын бүс нутаг болон бэлчээрийн ашиглалт, хамгаалалты талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Мал аж ауйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Аймаг дундын отрын бүс нутаг болон бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Бат-Эрдэнэ, Г.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун нар үг хэлэв.

Мэдээлэл сонссонтой холбогдуулан “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Б.Саранчимэг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 4
Бүгд: 10
60.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Байнгын хорооны гишүүд Аймаг дундын отрын бүс нутаг болон бэлчээрийн ашиглалт, хамгаалалтын талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Уг асуудлыг 16 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Мал аж ауйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун, мөн яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Довчинсүрэн, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны Хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Д.Эрдэнэбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, Ц.Идэрбат, Б.Саранчимэг нарын тавьсан асуултад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ауйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Наранчулуун нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Ж.Бат-Эрдэнэ, Х.Болорчулуун нар үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 28 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 17 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.САРАНЧИМЭГ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

2.Байнгын хорооны тогтоолын төсөл цаглавар батлах тухай байгаа.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 06 дугаар сарын 06-ны өдөр,
Мягмар гараг Төрийн ордон “Их засаг”
танхим 15 цаг 02 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Саранчимэг: Эрхэм гишүүдийнхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Тэгэхээр Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц 52.6 хувьтай бүрдсэн тул Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны 2023 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье. Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг та бүхэнд танилцуулах учиртай. Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна. Хаянгаагийн Болорчулуун гишүүн ирсэн байна. Наянтайн Ганибал гишүүн ирсэн байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна. Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүн ирсэн байна. Нанзадын Наранбаатар гишүүн ирсэн байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн ирсэн байна. Батсүхийн Саранчимэг гишүүн ирсэн байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн ирсэн байна. Одонгийн Цогтгэрэл томилолттой байна.

Бусад нь ирж байгаа юм байна. Та бүхэнд Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын сайдын мэдээлэл сонсох байгаа.

3.Аймаг дундын отрын бүс нутаг болон бэлчээрийн ашиглалт хамгаалалтын талаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох.

4.Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийн талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын мэдээлэл сонсох байгаа.

Сонсохын өмнө та бүхэнд ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг танилцуулъя. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын сайд Бат-Эрдэнэ, Болдбаатар Усны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Сайханжаргал Усны газрын Усны хяналт шинжилгээний хэлтсийн дарга, Мөнхзул Усны газрын усны хяналт шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн. Сангийн яамнаас ямар хүн байна? Татварын Ерөнхий газраас Буяннэмэх Татвар төлөгчид үйлчлэх газрын дарга, Мөнхдаваа татварын удирдлага, олон улсын татварын газрын гишүүн.

Бат-Эрдэнэ сайдыг мэдээллээ танилцуулахыг урьж байна 2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Эрхэм байнгын хороон дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын өргөтгөсний төлбөрийн тухай

хуулийн хэрэгжилтийн талаар та бүхэндээ танилцуулъя.

Улсын Их Хурлаар Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 2012 онд батлагдаж 2019 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тус хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр ашиглагч нь хамгаалагч бохирдуулагч нь төлөгч байх зарчмыг баримтлан бага бохирдуулбал бага, их бохирдуулбал их төлбөр төлдөг болж хаягдал усаа стандартад нийцүүлэн цэвэрлэж эргүүлэн ашиглаж байгаа иргэн аж ахуйн нэгж байгууллагыг төлбөрөөс хөнгөлөх чөлөөлөх зэргээр бодлогоор дэмжих асуудлыг тусгаж өгсөн байдаг.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль түүнийг дагалдан гарсан Засгийн газрын нэг тогтоол Засгийн газрын гишүүдийн хамтарсан 4 тушаал, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын сайдын 5 тушаал, усны чанарын 5 стандарт зэрэг 15 эрх зүйн баримт бичгээ бүрдүүлэн ажиллаж байгаа. Усны тухай хуулийн 24.2-т заасны дагуу хоногт 50 шоо метрээс их аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад дүгнэлт гаргаж тус дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа хоногт 50 шоо метрээс бага хаягдал ус гаргадаг аюултай бодис агуулаагүй. Ус бохирдуулагчдад бохирдуулагчид, сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум дүүргийн Засаг дарга хаягдал ус ашиглах зайлуулах, хаях зөвшөөрлийг олгож хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2020 оны хаягдал усны дүгнэлтээр 16.3 тэрбум 2021 онд 16.3 тэрбум төгрөг, 2022 онд 5.4 тэрбум төгрөг, 2023 оны эхний нэг хагаст 1.1 тэрбум төгрөг ноогдуулснаас 2023 оны 6 дугаар сарын 2-ны байдлаар 3.89 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Өөрөөр хэлбэл 2020, 2021 онд тухайлах юм бол 39.10, 39.2 тэрбум төгрөгийн төлбөрийг ноогдуулснаас өнөөдрийн байдлаар дөнгөж 3.8 тэрбум төгрөг л төвлөрсөн гэсэн маш хангалтгүй үзүүлэлттэй байгаа. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хаягдал усыг цэвэрлэж дахин ашиглах, эргүүлэн ашиглах бодлогыг дэмжих үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэх. Ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл стандартыг дэвшилтэт технологи шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу айл өрхийг 100 хувь чөлөөлж, ус, үйлдвэр, үйлчилгээндээ хаягдал усаа цэвэршүүлэн эргүүлэн ашигласан тохиолдолд эргүүлэн ашигласан усны хэмжээгээр төлбөрөөс чөлөөлдөг бөгөөд уул уурхайн компаниуд ихэвчлэн ашигласан усаа эргүүлэн ашиглаж байгаа. Уул уурхайн компаниудаас Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу 2020 онд 3.3 тэрбум төгрөг, 2021 онд 4 тэрбум төгрөг, 2022 онд 3.9 тэрбум төгрөг, 2023 оны эхний хагаст 0.9 тэрбум төгрөгийн төлбөрийг өнөөдрийн байдлаар чөлөөлөөд байна. Улсын хэмжээнд 96 хаягдал ус цэвэрлэх байгууламж байгаагаас цэвэршилтийн түвшнээр 90 хувьтай 29, 70-80 хувьтай 8, үлдсэн 37 цэвэрлэх байгууламж стандартын шаардлагад нийцэхгүй хаягдал бохир усыг хүрээлэн буй орчинд нийлүүлж байгаа.

Цэвэрлэх байгууламжид нийт хуучирсан урсгал засвар хийгдэхгүй удсаны улмаас ашиглалтын горим хангахгүй хаягдал усыг цэвэрлэлгүйгээр байгальд шууд нийлүүлж байгаа нь хөрс, ус бохирдох үндсэн нөхцөлийг бүрдүүлж байгаа. Ялангуяа Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламж ачааллаа даахгүйд хүрч стандартын хэмжээнд ажиллаж чадахгүй байгаа учраас Улаанбаатар хотын төв цэвэрлэх

байгууламжийг шинэчлэн орчин үеийн технологи бүхий цэвэрлэх байгууламжийг барьж эхлээд байгаа. Монгол Улсын Засгийн газар, АНУ-ын Мянганы сорилтын корпорацын 2 дугаар компакт гэрээний дагуу Төв цэвэрлэх байгууламжаас гарах 50 мянган м³ хоног усыг дахин боловсруулж дулааны 3, 4 дүгээр цахилгаан станцын техникийн өргөлтөд ашиглахаар ус дахин цэвэршүүлэх үйлдвэрийн төслийг эхлүүлээд явж байгаа. Уг зураг төсөл 60 хувьтай, барилга угсралтын ажил 5 хувьтай явагдаж байгаа мэдээ байна. Шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орж стандартын шаардлага хангасан усыг Туул голд нийлүүлж бохирдлыг бууруулахаас гадна ус гүн цэвэршүүлэх үйлдвэрийн технологийн шаардлагыг хангаж чадсанаар 50 мянган м³ хоног усыг дахин ашиглаж энэ хэмжээний усны нөөцийг хэмнэх боломжтой болж байгаа.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын тухайд 1 дүгээрт Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг, Усны тухай хууль, Төсвийн тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон бус бусад хуультай нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслийг боловсруулсан байгаа бөгөөд уг хуулийн нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаар батлуулахаар хүлээгдэж байна. Салбар хоорондын хамтын ажиллагаа сайжруулах шаардлагатай.

Тухайлбал тэр цэвэрлэх байгууламжууд өөрсдөө бохирдуулагч эх үүсвэр болоод байгаа өнөө үед Барилга, хот байгуулалтын яам, Зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Ус сувгийн удирдах газруудын хамтын ажиллагааг шинэ шатад гаргаж Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах цэвэрлэх байгууламжид нийлүүлж буй бохир усны чанарыг хянах үнэ тарифыг шинэчлэх шаардлагатай байна.

Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай

хуулийн 14.2.1-д заасны дагуу хангагч байгууллага нь хүлээн авч буй бохир усны чанарт хяналт тавьдаг болох ус ашиглагч иргэн аж ахуйн нэгж байгууллага тус хуулийн 15.1.5, 18.5-д заасныг мөрдөх нөхцөлийг бүрдүүлж хаягдал ус, шугамд нийлүүлэх MNS 6561 2015 стандартыг мөрдүүлэх шаардлагатай байна.

Дөрөвдүгээрт, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулахад байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи, олон улсын туршилага, менежментийг нэвтрүүлэх, шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хил, гаалиар нэвтрүүлэхэд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, ногоон зээлд хамруулах, эдийн засгийн хөшүүргийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Тавдугаарт, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад иргэн, аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, мэдээллээр тогтмол хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр урьдчилан таниулах арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай.

Зургаадугаарт, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг төлөвлөж байгууллагын төсөвт жил бүр тусгуулах арга хэмжээг авах, шаардлагатай.

Долоодугаарт, Ус бохирдуулсны төлбөрийн орлогын усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг бууруулах, арилгах, хяналт шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба нийт орлогын 50-аас доошгүй хувийг тухайн цэвэрлэх байгууламжийн шинэчлэл засвар үйлчилгээнд зарцуулах боломжийг бүрдүүлж ус бохирдуулсны төлбөр нь байгаль орчин, уур амьсгалын санд шилжин хүрээлэн буй орчныг бохирдох, доройтохоос хамгаалах, бууруулахад шаардагдах зардлыг жил бүр тусгах шаардлагатай гэж үзэж байна.

Хаягдал усыг тоолууржуулах ажлыг эрчимжүүлж, хаягдал усанд шинжилгээ хийдэг лабораториудыг итгэмжлэх, хамрах хүрээг өргөтгөн хаягдал усны стандартад заасан үзүүлэлтүүдийг бүрэн шинэчлэх техникийн болон хүний нөөцийн чадавхыг бүрдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай гэж үзэж байна. Иймд эдгээр ажлыг хэрэгжүүлснээр Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт сайжирч аж ахуйн нэгж байгууллагуудын хаягдал усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэх, цэвэрлэсэн усыг эргүүлэн ашиглах үйл явцаар дамжуулан цэвэрлэх байгууламжийн ачааллыг эрс багасгах, хүрээлэн буй орчныг бохирдлоос сэргийлэх бодитой хувь нэмэр оруулна гэж үзэж байна. Баярлалаа.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулттай гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа.

Болорчулуун сайд асуултаа асууя.

Х.Болорчулуун: Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас ус бохирдуулсан төлбөрийн тухай хэрэгжилтийн танилцуулгыг сонслоо.

Энэ ус хамгийн их хэрэглэдэг газар уул уурхайн салбар тэрэн дотор Монгол Улсад хамгийн их гүний усыг хэрэглэж байгаа ийм газар Оюу Толгой компани. Говьд бол ус гэдэг алт. Оюу Толгой компанийн усны төлбөрийг нэмэгдүүлэх асуудал яригдаж байсан энэ ямар шатанд явж байна вэ? Ер нь Оюу Толгой компани бол тогтвортой байдлын гэрээ хийчихсэн гээд ихэнх татвар дээрээ хөдөлгөөн байхгүй байдаг. Харин усан дээр бол тогтвортой байдлын гэрээ харин хийгээгүй юм байна лээ. Тэгэхээр говьд алтаар үнэлэгдэх энэ уснаасаа бид нар ядахдаа төлбөрийг олон улсын жишигийн

дагуу авах хэрэгтэй байна. Энэ тал дээр ямар ажил хийгдэж байна гэдгийг асууя.

Б.Саранчимэг: 4 номер хариулъя. Өөрсдийгөө дахиад танилцуулаад явчхаарай.

Я.Болдбаатар: Өдрийн мэнд хүргэе. Усны газрын дарга Болдбаатар байна. Болорчулуун гишүүн Оюутолгойтой холбоотой асууж байна. Оюу Толгой компани бол жил болгон бол нөгөө ус ашиглалтын дүгнэлтийг бол гаргуулаад явж байгаа. Хаягдал бохир усан дээр бол тодорхой хэмжээний нөгөө хөрөнгө оруулалтын гэрээнд тусгагдаагүй гэдэг үүднээс бол хаягдал усны төлбөрийн дүгнэлт гаргуулаагүй төлбөр тооцоог одоогоор хийгдээгүй явж байгаа. Энэ дээр ер нь бол урьдчилсан байдлаар энэ хаягдал усных нь төлбөр тооцоог бол манайхаас бол хийгээд явж байгаа.

Ер нь энэ усны төлбөртэй холбоотой бусад асуудлууд нь бол яг усны түвшин нөөц энэ тэр нь бол мониторингийн хяналтаар бол ингээд байнга хянагдаад улирал тутам тайлан мэдээг нь аваад ингээд үзээд явж байгаа. Усны үнэ дээр бол сая нөгөө 2013 оны 326 дугаар тогтоолыг бол зэс, нүүрс, алт дээр нь архи, пиво, ундааны үйлдвэрүүд дээр үнийг нь нэмж 20 хувь байсны 35 хувиар бол нэмж тогтоож 416 дугаар тогтоолоо Засгийн газрын тогтоолоор баталсан. Үүнтэй холбогдуулаад энэ ашиглалтын энэ ус ашигласны төлбөр бол нэмэгдэж энэ жилээс нэмэгдэж орж ирж байгаа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд тодруулъя.

Х.Болорчулуун: Ус бохирдуулсны төлбөр тийм ус ашигласны төлбөр манайх олон улсын жишигээс хамаагүй бага авдаг юм байна лээ хэд дахин бага авдаг. Тэгэхээр энийг тэр олон улсын жишигт ойртуулах хэрэгтэй байна шүү дээ. Олон улсын гэрээ гэж байгаа шүү дээ энэ чинь одоо. Энэ тал дээр бас тэр усны

газрын дарга Мягмар энэ тэр байхдаа нэг санал боловсруулаад ийм болгох нь зүйтэй гэсэн асуудал явагдаж байсан. Тэгээд чимээгүй болчихлоо л доо, ус ашигласны төлбөрийг. Энийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна Оюу Толгой дээр. Энэ тал дээр ямар ажил хийгдэж байна вэ л гэж бас устай холбоотой юм л асууж байна.

Б.Саранчимэг: Болдбаатар дарга тодорхой хариулъя даа. 4 номерын микрофоныг өгье. Кнопоо битгий дараарай шууд автоматаар орж байгаа.

Я.Болдбаатар: Энэ дээр Усны тухай хууль дээр бол энэ усны нөгөө экологийн эдийн засгийн үнэлгээ гэж байж байгаа. Дээр нь сав газар болгоноор ингээд гадаргын усан дээр газрын доорх усан дээр гээд ингээд үнэлгээ тогтоочихсон байдаг.

Дээр нь Усны тухай хууль дотор бол яг энэ усны нөгөө газрын доорх усны үнэ тарифыг бол ингээд заачихсан байдаг. Тэгэхээр зэрэг сая нэмэгдээд яг Усны хуульдаа заасан яг хамгийн дээд хязгаарт нь бол 35 хувиар тулчхаад байж байгаа юм. Тэгээд хэрвээ энэнээс дээшээ төлбөрийг нэмнэ гэвэл хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай болчихоод байж байгаа юм.

Б.Саранчимэг: Дараа нь санал дээр бас хэлж болно.

Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Усны хуулийн хэрэгжилт ер нь байгаль орчны нөөц ашигласны төлбөрийн асуудал дээр бас Байгаль орчны яам нэлээн бас санаачилгатай ажиллаж байгаль орчинд зарцуулах ёстой хөрөнгийг нэмэгдүүлэх тал дээр бас нэлээн санаачилгатай ажиллаж байгаа гэж ингэж бас харж байгаа. Яах вэ орон нутагт олон асуудлууд байдаг. Тэрийгээ шийдэхийн тулд зарим зүйлүүд бас өөр зүйлүүд рүү ордог. Хөрөнгө оруулалтууд руу ч орчихдог ийм зүйлүүд бас байсан. Энэ жилээс бас нэлээн сайн шахаж ингэж

ажиллаж байгаа юм билээ гэж ингэж харж байгаа.

Миний эхний асуулт сая Болорчулуун сайд бас асуучихлаа л даа. Уул уурхайтай холбоотой ялангуяа говьд байгаа тэр усны нөөцийг бид хадгалахын тулд ямархуу арга хэмжээ авах ёстой юм. Таны хэлснээр бол сая хуулийн дээд хязгаар тулчихлаа гэж ингэж хэлж байна л даа. Тэгэхээр одоо энэн дээр хуулийн дээд хязгаарыг сая Болорчулуун сайдын бухимдаад байгаа тэр зүйлийг дээшлүүлэх таазыг нь дээшлүүлэх ямар санал санаачилга гаргаж байгаа юм бэ?

Тэгээд та нөгөө энийг дутуу хариулчихсан учраас би тодруулаад асуучихъя гэж ингэж бодож байна. Болдбаатар даргаас.

Хоёрдугаарт, Монгол Улсын энэ төв суурин газруудын цэвэрлэх байгууламжууд бас нэг үеэ бодвол харьцангуй шинэ шинэ зүйлүүд баригдаад ер гаруй хувийн цэвэрлэгээтэй ийм болж байгаа. Тэгэхээр тэр нэг саарал ус гэж яригдаад байдаг энэ бусад зүйлүүд дээр ундны уснаас бусад хэрэглээн дээр ахуйн хэрэглээнээс бусад хэрэглээн дээр хэрэглэх ийм зүйлийг ярьж байгаа юм. Тэгэхээр яг өнөөдөр Монголд ер нь яг энэ саарал усыг хэрэглэж байгаа технологи юмнууд байна уу?

Дээрээс нь аймгууд дээр энэ мал нядлах гэх үү дээ. Энэ бой янз янзын үйлдвэрүүд баригдаад байгаа. Эд нарын бохирын асуудал бас байдаг. Цэвэрлэх бага оврын асуудлууд бас яригдаад байдаг. Энэ дээр бас яг жишиг болгохоор очоод үзүүлчихээр ийм одоо бас цэвэрлэх байгууламж нөгөө төвийн шугамд шууд нийлүүлж болохгүй шүү дээ тэр чинь. Тийм зүйлүүд бас байна уу? Саарал ус энэ 2 дээр би асуух гээд байгаа юм.

Б.Саранчимэг: 4 номерын микрофоныг өгье.

Я.Болдбаатар: Асуултад хариулъя. Түрүүн бас Оюу Толгойн

асуудал бас давхар давтагдаж байна. Тэгэхээр зэрэг яг Оюу Толгой дээр бас яг ашиглалтын төлбөрөө л төлөгдөөд явж байгаа. Дээр нь бол энэ яг Усны тухай хуулиараа ус хэрэглэгч ашиглагч гээд 2 хуваагддаг. Энэ дээр бол нөгөө хүн амын унд ахуйн усны төлбөр бол энэ дээр бас яригдах ёстой. Орон нутгаас бол энэ хүн амын унд ахуйн ус төлөгдөхгүй байна. Тодорхой хэмжээний энэ төлбөрүүд орох ёстой гэдэг дээр бол бас санал тавьж байдаг. Энэ маань өөрөө хууль дээр бол унд унд ахуй гэдгээрээ од төлбөрөөс чөлөөлөгдөнө гээд явчихсан учраас бол энэ энэн дээр бол бас цаашид бид нар хуулийн зохицуулалт хийж явах шаардлагатай гэж үзэж байгаа юм.

Дээр нь түрүүн би хэлсэн хаягдал усны төлбөр гэдэг дээр нэг хөрөнгө оруулалтын гэрээ нь тусгагдаагүй учраас энэ бол бас төлөх боломжгүй гээд. Энэ 2 төлбөр бол Оюу Толгой компаниас одоогоор төлөгдөхгүй ингээд явж байгаа. Дээр нь одоогийн Байгаль орчны багц хуулиуд тэр дотор Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шинэчлэх чиглэлээр бол энэ хуулиудын төсөл ингээд хийгдээд явж байгаа. Энэ төсөл дээр бол энэ асуудлуудыг тусгаж оруулна гэсэн ийм бодолтой явж байгаа.

Саарал устай холбоотой ер нь саарал ус маань манай улсад бас яг эрх зүйн орчин бол бас тийм сайн биш. Улсын Их Хурлын 2 тогтоолд 1, 1 өгүүлбэр байдаг. Нэг стандарт бол батлагдсан байж байгаа. Тэгээд энэний дагуу бол нийтдээ саарал усны ашиглалт бол дэд бүтцээс гадна одоо барилгын тэр зураг төсөлд нь бол анхнаас нь анхан шатаас нь ингэж тусгаж өгч оруулж байж тэр барилга байгууламжийн бүтээн байгуулалтын үед нь бол тэр дэд бүтцийг нь бол хийж өгөх шаардлагатай байдаг. Саарал усан дээр бас тодорхой хэмжээний бас дүрэм журмууд, төлбөрийн асуудал бас энэ дээр давхар зохицуулалтын асуудал хийх шаардлагатай байгаа юм.

Энэ дээр бол бас нөгөө Барилга, хот байгуулалтын яамтай бол хамтарч ажиллах талаар бид нар санал яриад явж байгаа юм.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Саарал усан дээр яг ашиглаж байгаа тийм кэйс байна уу л гээд байгаа шүү дээ? Би 1 дүгээрт.

Хоёрдугаарт тэр юуны бага оврын цэвэрлэх байгууламжууд ялангуяа орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аймгийн төвүүд дээр ашиглах боломжтой цэвэрлэх байгууламжуудын кэйс бас байна уу?

Б.Саранчимэг: 3 номер хариулъя.

Д.Сайханжаргал: Усны газрын хэлтсийн дарга Сайханжаргал байна. Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тэгэхээр саарал усыг ашиглаж байгаа тохиолдол бидэнд байна. Улаанбаатар хотод бол нөгөө саун бассейнд ашигласан усаа бид нар машин угааж байгаа тохиолдол бид нарт байгаа. Мөн нөгөө ус ундааны үйлдвэр Кока колагийн дахин цэвэршүүлсэн усыг бид нар Амгалан дулааны цахилгаан станц ч байдаг юм уу аль эсвэл ойр орчмын машин угаалгын газруудад бас ашиглах боломж энэ байгаад байгаа юм. Бид нарт бас нэг асуудал юу байгаа вэ гэхлээр ер нь бид нар цэвэр усаараа машин угаахгүй ер нь дахин ашиглах усыг нэмэгдүүлье гэж бодох юм бол бид нар дахин ашиглах усны нөөцөө нэмэгдүүлэх шаардлага байгаад байгаа.

Энэ дээр ямар асуудал үүсэж байна гэхээр томоохон үйлдвэр ус ашиглагч нар дээр урьдчилан цэвэрлэх байгууламж байна. Урьдчилан цэвэрлэх байгууламж.../минут дуусав/.

Б.Саранчимэг: Саарал усыг яг хаана ашиглаж байгаа вэ гээд тодорхой асуусан шүү дээ тэ. Тэгээд 3 номерын микрофон дээр дахиад өгье дөө.

Д.Сайханжаргал: Улаанбаатар хотод бол нөгөө Соёл велнес гээд амралт сувиллын газар байгаа. Тэгээд тэрний усыг нөгөө бассейндаа болон амралтын газартаа хэрэглэсэн ахуйн усыг дахин чийгшүүлээд машин угааж байгаа тохиолдол бид нарт байгаа. Мөн Эм Си Эсийн Кока кола үйлдвэрээс гарч байгаа 2000 м³ усыг бид нар дахин цэвэршүүлээд тэгээд энэ ойр орчмын машин угаалгын газар болон мод усалгаанд Улаанбаатар хотын ногоон байгууламжийг услах асуудалд бас ашиглаж байна. Хөдөө орон нутагт байгаа уул уурхайд бид нар дахин ашиглаад нөгөө тоосжилт замын тоосжилт дарж байна. Мөн энэ тэрбум модтой холбоотойгоор уул уурхайн аж ахуйн байгууллагууд хариуцлагаа гаргаад л. Энержи ресурс байна, Оюу Толгой өөрөө ашиглаж байна.

Б.Саранчимэг: Манай гишүүдийн асуултад маш тодорхой хариулаарай. Одоо тэр саарал ус гээд тэгэхээр чинь нөгөө Улаанбаатарт хоёрхон газар л ашиглаж байгаагаар ярьж байна шүү дээ. Тэгэхээр 2012 онд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг батлаад 2016 онд яг бас нэмэлт, өөрчлөлт оруулсан байгаа. Тэгэхээр өнөөдөр бид нар яг энэ хууль ямар хэрэгжилттэй байгаа вэ. Өнөөдөр маш олон газрууд энэ усыг ашиглаж байгаа шүү дээ. Тэгэхээр бид нар гүнийхээ усыг ашиглаж байгаа энэ үед саарал усыг ашиглах эсвэл их бохирдуулсан төлбөрөө их төлөх бага бохирдуулсан зохих хэмжээнийхээ төлбөрийг төлөх энэ хуулийн зохицуулалт байгаа.

Тэгэхээр энэ дээр манай бас хариуцаж байгаа усны газрынхан бас тодорхой сайн хариулт өгөхийг хүсэж байна.

Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Энэ хууль хэрэгжээд бас нэлээдгүй хугацаа өнгөрч байна. Тэгээд ер нь бид нар бас энэ усны төлбөрөөс орж ирж байгаа төвлөрлийг бий болгох тал дээр бас нэлээн анхаарч

ажиллах ёстой байгаад байдаг. Гэтэл энэ 2020 онд гэхэд бид нар 16.31 тэрбум гэж байна 2021 онд 16.34 тэрбум 2022 онд гэхэд л 5.44 тэрбум 2023 оны эхний хагас жилд гэхэд 1.16 тэрбум төгрөг ноогдуулсан гээд ингээд нэг баахан төлбөр ногдуулчихсан байгаад байгаа юм байна л даа. Гэтэл өнөөдөр 2023 оны 6 сар гэхэд ер нь 3 тэрбум төгрөг улсын төсөвт төвлөрүүлсэн гэж байна тийм үү? Тэгэхээр яагаад энэ төлбөрүүд ингэж бага хэмжээгээр төвлөрөөд байгаа юм бэ? Энэ дээр ямар стандарт тогтоогоод ер нь авсан юмнууд маань ийм бага хэмжээтэй төвлөрсөн байгаа юм. Энэ дээр Байгаль орчны яам ямар хариуцлага тооцож ингэж ажиллаж байгаа юм бэ гэдэг ногдуулсан төлбөртэй холбоотойгоор асуулт байна.

Түрүүн манай гишүүд ихэнх нь яриад байна. Ер нь энэ ундны ус үгүй болж байгаа. Ер нь бол энэ говийн нөхцөл байдал бас хүндэрч байна. Ус гэдэг бол юун алтны байтугай амины үнэтэй болсон ийм цаг үед энэ говийн усыг бас сэргээх юм уу? Энэ саарал уул уурхайд ашиглах тал дээр байгаль орчин ер нь ямар стандарт тогтоож, ингэж харьцаж, хандаж ажиллаж байгаа юм бэ гэдэг асуултаудыг тавиад энэ дээр бас би нэмж ямар уул уурхай энэ та нарын мэдээлэл дотор байж байна л даа. Уул уурхайн компаниуд саарал ус ашигладаг болсон гээд. Тэгээд сая давхар давхар асуугаад байна. Ер нь ямар компани яг уул уурхайн чиглэлээр компани ийм жишиг болохуйц бүүр кэйс болохуйц ийм хэмжээний саарал усыг ашиглаж байгаа, үйлдвэртээ ашиглаж байгаа байгаль орчинд ашиглаж байгаа ийм жишээ сайн жишээ байгаад байгаа юм байна. Бид нар олон жил бас ингээд л саарал ус ашиглана. Энэ усны төлбөртэй холбоотой асуудлуудыг олон жил ярьж байна. Тэгээд үнэхээр жишиг болохуйц ийм хэмжээний том бүтээн байгуулалтуудыг хийчихсэн ийм уул уурхайн компаниудаас санал санаачилга гарсан зүйл байна уу? Энэ дээр манай Уул уурхай, Байгаль орчны яам өөрөө бас ямар хараа хяналт тавьж ажиллаж байгаа юм бэ? Сайн жишээүүдийг бид нар бас цааш

нь бас ингээд уламжлах гэдэг юм уу, цааш нь хэрэгжүүлэх дээр бид нар анхаарч бас ажиллах ёстой байгаад байгаа. Энэ дээр уул уурхайн компаниудад жишиг болгох юм байна уу үгүй юу тийм ээ.

Ийм мэдээлэлтэй холбоотойгоор асуултуудыг тавья.

Б.Саранчимэг: Мөнхцэцэг гишүүн маш чухал асуултыг асуулаа. Тэгэхээр яг ийм тодорхой онуудад тодорхой төсвүүдийг бас ингээд орлого болгож улсын төсөвт төвлөрүүлжээ. Тэгээд энэ төсөв чинь эргээд бас энэ усан санд төвлөрүүлэх, усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт шинжилгээ хийх, нөхөн сэргээх гээд ингээд 50-аас доошгүй хувийн цэвэрлэх байгууламжийн шинэчлэл зарцуулна гэсэн байгаа. Тэгээд энэ дээр нь бас нэмээд энэ мөнгөнүүд чинь яг ингээд зарцуулагдаж байгаа юу энэний хэрэгжилтийг ямар байгаа вэ гэдэг дээр бас илүү тодорхой хариулт өгчхөөрэй. Хэн хариулах вэ?

3 номер хариулъя.

Д.Сайханжаргал: Тэгэхээр бид нар өнөөдрийг хүртэл нөгөө ноогдуулсан нь үнэхээр 40 орчим тэрбум ноогдуулаад өнөөдөр 3,8 тэрбум төгрөгийн орлого бүрдсэн байна гэдэг дээр тайлбар хэлэхэд хууль маань өөрөө яг хүн амын унд ахуйгаас гарч байгаа бохирдлыг болон мөн 4 чиглэлээр дээр нь нөгөө нэг эрүүл мэндийн байгууллага, боловсрол, тэгээд халамжийн байгууллагуудыг төлбөрөөс чөлөөлдөг байгаа. Тэгэхээр энэ 4 чиглэл дээрээ гэхээр бид нар 14.9 тэрбум төгрөгийг ингээд чөлөөлчхөж байгаа юм хуулиар нь. Тэгэхээр бид нар үлдсэн 20 тэрбум төгрөг хаанаас бүрдэхгүй байна вэ гэхээр энэ яг хот суурины ариутгах татуургын үйлчилгээг хариуцаж байгаа энэ манай Улаанбаатар хотод болоод төв цэвэрлэх байгууламжаар харилцаж байгаа. Ус суваг дээр өнөөдөр 2020 онд 8 тэрбум төгрөгийн, 2021 онд 9 тэрбум төгрөгийн ингээд нөхөн төлбөр ногдуулчихаад байгаа юм. Энэ нь яагаад гэхээр стандартын шаардлага хангахгүй

тохиолдолд нөхөн төлбөр тооцогдоно гээд хуулиараа байгаа учраас. Тэгэхээр нөхөн төлбөрийн асуудлыг Ус суваг, Барилга, хот байгуулалтын яам гэх юм уу толгой байгууллага нь. Тэгэхээр эд нар маань бид нар ялгаа байхгүй төсвийн юу учраас ингээд төлөх боломжгүй гээд байгаа боловчиг нөгөө талдаа хуулиа үзэх юм бол цэвэрлэх байгууламжаа яг өөрсдөө хариуцдаг. Цэвэрлэх байгууламжийн тусгай зөвшөөрлөө олгодог. Гэтэл бол одоо гарч байгаа ус нь Туул гол болон хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулаад байгаа.

Тэгэхээр энэ дээр авч байгаа усныхаа чанар дээр хяналт тавиад бид нартай хамтраад ажиллах боломж байна уу гээд тэгээд бас бид нар өнөөдрийн хуралдаанаар та бүхнээс яг энэ дээр яг салбар хоорондын уялдаан дээр бид нарыг дэмжээд өгөөсэй гэж бас нэг хүсэж байгаа юм. Тэгээд яг сайн туршилага гэдэг дээр манай хэн хариулчих уу?

Б.Саранчимэг: 4 номерын микрофоныг өгье. Тэр бас саарал ус гээд тодорхой асуулт асуусан шүү.

Д.Мөнхзул: Усны газрын усны хяналт шинжилгээний хэлтсийн ахлах мэргэжилтэн Мөнхзул.

Энэ саарал ус гэдэг нь өөрөө болохоор ерөөсөө ахуйн хэрэглээнээс гарсан угаалга цэвэрлэгээнээс гарсан хаягдал бохир усыг л саарал ус гэж ярьж байгаа. Саарал усыг эргүүлэн ашиглах талаар өнөөдөр Монгол Улсын хэмжээнд яригдана гэх юм бол яг түрүүн Болдбаатар даргын хэлсэн шиг анхнаасаа барилга байгууламжийн нөгөө шугам хоолойн төлөвлөлт хийхдээ саарал усыг эргүүлэн ашиглах адаглаад нөгөө эргээд угаалга цэвэрлэгээнээс гарсан хаягдал бохир усыг тухайн барилга байгууламжийн дэргэд байрлах цэвэрлэх байгууламжид урьдчилан цэвэрлээд эргээд тухайн байгууллагынхаа юм уу барилга байгууламж орон сууцныхаа почкиний усанд хүртэл эргүүлэн хэрэглэх

боломжтой байгаа. Унданд ашиглахаас бусдаар саарал усны стандартыг хангасан тохиолдолд эргүүлэн ашиглах боломжтой. Гэтэл өнөөгийн нөхцөлд орон сууц нийт нийтийн манай хэрэглээнээс зөвхөн угаалга цэвэрлэгээнээс гарч байгаа энэ усыг тэр соёл велнесээс өөр цэвэрлээд эргүүлэн ахуйн хэрэглээндээ ашиглаж байгаа тохиолдол байхгүй байгаа. Нөгөө талаар хаягдал ус гэдэг дээр эргүүлэн ашиглаж байгаа хаягдал ус буюу технологийн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал бохир усыг үйлдвэрт ашиглаж байгаа тохиолдол бол зөндөө байна.

Ялангуяа нийслэлийн хэмжээнд арьс ширний үйлдвэрүүдийг бид нар технологийн хэрэгцээндээ та нар өндөр их хэмжээний ус хэрэглэж байгаа учраас энэ урьдчилан цэвэрлэх байгууламж заавал суурилуулаад технологийн хэрэгцээндээ газрын доорх ус цэвэр усаар ашиглахгүй. Энэ урьдчилан цэвэрлэх байгууламжаас гарсан стандартын шаардлага хангасан усаа эргээд технологийн хэрэгцээндээ ашигла. Ингэсэн тохиолдолд ус бохирдуулсны төлбөрөөс 100 хувь хөнгөлнө өө гэж үзэж байгаа.

Уул уурхайн хувьд ихэнх уул уурхай 75-аас 85 хувь хүртэл технологийн хэрэгцээний бохир ус хаягдал усыг эргүүлэн ашигладаг. Ингэхдээ хаягдлын сангаар дамжуулан байгалийн өөрөө цэвэрших юм уу эс үгүй бол урьдчилсан цэвэрлэх байгууламж суурилуулаад цэвэрлэх байгууламжаас MNS 4549432015 стандартын шаардлагыг хангасан хаягдал бохир усыг байгальд нийлүүлж байгаа тохиолдолд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар 100 хувь хөнгөлж байгаа.

Татварынхан хариулах уу? Энэ орлого чинь яагаад эргээд нөгөө энэ зориулалтаараа ашиглагдаж байгаа юу?

Тэгээд яг ямар уул уурхай гэдгийг бас Мөнхцэцэг гишүүн асуусан шүү дээ.

Тэрэн дээр бас нэмж хариулаарай. Мөнхцэцэг гишүүн тодруулж асууя.

Г.Мөнхцэцэг: Сая ингээд л байна л даа яах вэ ер нь 3 жилийн хугацаанд 40 гаруй тэрбум төгрөгийн төлбөр ноогдуулсан байна тийм ээ. Тэрнээсээ өнөөдөр нэг 3 тэрбум л улсын төсөвт төвлөрсөн байна гээд байна. Энэнээсээ бид нар 14.9 тэрбумыг нь тодорхой хэмжээгээр авах бололцоотой. Бусад нь ингээд үндсэндээ 2 салбарын ч гэдэг юм уу ямар нэгэн зохицуулалтгүйгээр авах бололцоогүй байгаад энд юунд хүрээд байна л гэж та нар хариулж байгаа юм байна л даа.

Тэгэхээр өөр ямар нэгэн байдлаар энийгээ төвлөрүүлэх тал дээр нь нөхөн төлбөр оногдуулах тал дээр нь өшөө ямар аргачлал байгаа юм, ямар гарц байна? Тийм ээ энэ дээр бас яам яаж харж байгаа юм бэ? Тэгээд Байнгын хорооноос нэг тогтоол гаргуулаад нэг чиглэл өгөөд энэ зохицуулалтыг хийж өгөөч ээ гэж байгаа. Өнөөдөр энэ бас худлаа л даа.

Тэгэхээр энэ дээр та нар бас ямар юутай байгаа юм гарц гаргалгаа байгаа юм гэдгийг уул нь сонсьё гэж ингэж бодсон юм. Тэгээд яах вэ? Яг манайд уул уурхай дээр ингээд үнэхээр нэг тийм шилдэг жишээ болохуйц ийм хэмжээний саарал ашиглаж байгаа тийм уул уурхайн компани бол энэ дээр бас алга л байна л даа. Та нарын энэ ярьж байгаа дүгнэлтээс харах юм бол байхгүй л байгаа юм байна.

Аж ахуйн нэгжүүд бол өөрсдөө усаа боловсруулаад буцаагаад.

Б.Саранчимэг: Болдбаатар дарга хариулъя. 4 номерын микрофон.

Я.Болдбаатар: Энэ дээр яах вэ түрүүн бас ялгааг нь хэллээ. Саарал ус гэдэг маань бас тусдаа өөр ойлголт. Технологид ашиглаж байгаа ус маань нөгөө эргүүлэн буцаагаад ашиглаж байгаа бол дахин буюу эргүүлэн ашигласан ус гэдгээ бас нэр томъёоллоор

бол явж байгаа юм. Тэгэхээр уул уурхайнууд дээр бол тодорхой хэмжээнд бол саарал ус гэдэг маань зөвхөн ахуйгаас нь гарсан усаа л цэвэршүүлж эргүүлж ашиглах гэдэг асуудал дээр ярьж байна. Технологийн усыг бол эргүүлээд сая бас хэлж байлаа 70-аас 80 хувийг нь бол тодорхой хэмжээнд ялангуяа говийн районд бол 80, 90 хувьтай бол эргүүлэн ашиглах ийм процесс бол бас явагдаж байгаа.

Эндээс цаашидаа бол бид нар энэ ахуйн саарал усыг бол дахин ашиглах дээр Барилга, хот байгуулалтын яамтайгаа ярьж байгаад энэ эрх зүйн зохицуулалтын дүрэм журмыг шинэчлэн боловсруулах дээр нь стандартуудыг нэмж боловсруулах энэ тэр гэсэн ийм ажлуудыг бол зайлиггүй хийх шаардлага тулгараад байгаа.

Б.Саранчимэг: Өнөөдөр бид нар бас энэ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг дахин хэлэлцэж байна. Түүрүү бас түүрүү жил жилийн өмнө ус бохирдуулсны төлбөрийн тухай хэрэгжилтийн явцыг бас танилцуулсан байгаа. Тэгэхээр нэлээн олон асуудлыг бас шийдвэрлэхээр явж байна гээд ярьсан. Тэгэхээр энэ хугацаанд яг ямар ахиц дэвшил гарсан юм бэ?

Дээрээс нь улсын төсөвт өнөөдөр 2023 онд ингээд анх хууль батлагдсаны дараагаар 2021 онд 16.4 байснаа сүүлдээ ямар ч саарал ус ашиглаагүй мөртөө нөгөө төлбөр чинь бүүр эрс багасаад 3.8 болчихсон байх жишээний. Тэгэхээр энэ төлбөр чинь улсын төсөвт хуримтлагдаад бас зориулалтаараа ашиглагдаж байгаа юу гэсэн нэг ийм тодорхой бас асуулт байна.

Тэгээд ямар ахиц гарсан бэ гээд түүрүүн тэгээд тэрэн дээр асуусан энэ татварын газар хэн Байгаль орчны сайд энэ дээр бас нэмж хэлэх үү?

2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Байнгын хороон даргын асуултад хариулъя.

Нийт яах вэ нийт төлөх ёстой ноогдуулсан төлбөрийн хэмжээгээр 39 тэрбум төгрөг төлөгдөх ёстой байгаа. Гэтэл энэний дийлэнх хувь буюу 17 тэрбум төгрөг нь дангаараа Улаанбаатар хотын УСУГ-тай холбоотой төлбөр болчхож байгаа юм. 2020 онд 9.7 тэрбум төгрөг, 2021 онд 8 тэрбум төгрөгийн ийм төлбөр ноогдуулсан. Энэ төсөвт төвлөрүүлэх ёстой төлбөр. Энэ өнөөдрийг хүртэл төлбөр төвлөрөөгүй байгаа юм.

Улаанбаатар хотын захирагчаас бол Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд Ус сувгийн удирдах газар энэ төлбөрийг бол төлөх эрх бүхий субъект нь биш ээ гэдэг албан бичиг ирсэн. Бид нар бол төлөх ёстой субъект нь мөн гэж үзэж байгаа юм. Ялангуяа Барилга, хот байгуулалтын яам, Ус сувгийн удирдах газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар гэсэн энэ гуравласан энэ 3 газар дээр бол энэ Туул голыг бохирдуулж байгаа ялангуяа дээрээс нь энэ төв цэвэрлэх байгууламжтай холбоо бүхий ус бохирдуулсны төлбөртэй холбоо бүхий асуудал энд үүсчхээд байгаа юм.

2022 оноос бид нар Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль 21 хувьтай байсныг АТГ-тай хамтарч ажилласны хүрээнд 44 хувь болгосон. 2022 онд бол 44 хувийн хэрэгжилттэй явж байгаа. Сая бид нар Улсын Ерөнхий прокурорт бол албан ёсны хүсэлтийг тавьсан. Одоо өнгөрсөн хугацаанд бид нар Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль болон Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах гэж удаа дараалан аймгийн Засаг дарга, нийслэл, тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон холбогдох байгууллагуудад АТГ-тай хүртэл хамтарч ажиллалаа. Тодорхой үр дүн гарч байна. Гэхдээ цагаан дээр хараар бичигдсэн энэ хууль бол хэрэгжих ёстой.

Тийм учраас бид нар 2023 оноос бол шууд хууль хяналтын байгууллагатай хамтран ажиллах энэ ажлыг бол бид нар шууд эхлүүлээд явж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Барилга, хот байгуулалтын яамтай бол бид нар энэ Төв цэвэрлэх байгууламжтай холбоо бүхий энэ Ус сувгийн удирдах газрын манай Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас төлбөр ноогдуулсан 17.7 тэрбум. Энэ бол нийтдээ уул нь бол бүүр 22 тэрбум төгрөгийн асуудал байгаа юм. Тэр 22 тэрбум төгрөгөөс тодорхой төсвөөс санхүүждэг эрүүл мэндийн байгууллага төсвөөс санхүүждэг боловсролын байгууллага төлбөрөөс чөлөөлөгддөг айл өрх төлбөр ноогдуулсан ААНБ-тай холбоо бүхий асуудлуудыг нь хассаар байгаад л тэгээд 17.7 тэрбум төгрөг дээр очсон эцсийн дүн.

Тэгээд энийг бол бид нар барагдуулахаар ажиллаж байгаа. Түрүүний хэн Болдбаатар даргын хэлээд байгаа эрх зүйн орчин дээр тодорхой хэмжээний өөрчлөлтүүд зайлшгүй орох шаардлагатай байгаа гэдгийг бол бид нар мэдэж байгаа. Өнгөрсөн жил орчмын хугацаанд бол бид нар Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуультай холбоо бүхий асуудлууд болон түрүүний Болорчулуун гишүүний бас асуудаг Засгийн газраар хэлэлцэгдээд Уул уурхайн яам маань бас тодорхой хэмжээнд эсэргүүцсэн. Гэхдээ энэ дээр бол бид нар Засгийн газрын хуралдаанаас нэгдсэн саналаар бол бас эцэслэн шийдвэрлэж тодорхой төлбөр мөнгийг бол нэмэгдүүлээд ингээд ажиллаж байгаа.

Тэгээд бид нар бол одоо Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль болон Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн асуудлаар бол Улсын ерөнхий прокурорт хандаад явж байгаа гэсэн үг.

Б.Саранчимэг: Тэгэхээр бид нар гол энэ хуулийг баталсан нь бол усныхаа бохирдлыг бууруулах, ялангуяа 2013 оны усны бохирдлын тэр түвшинд л хүргэх зорилготой явж байгаа шүү дээ. Тэгээд энэ нөгөө хуримтлагдсан мөнгө чинь

эргээд зарцуулагдаж байгаа юу зориулалтын дагуу зарцуулагдаж байгаа юу гэдгийг бас нэг асуугаад байна шүү дээ. Тэгээд энэ дээр нэг тодорхой энэ татварын газраас юм уу хаанаас хариулах юм. хэн хариулах вэ? Болдбаатар дарга хариульа 4 номерын микрофон.

Я.Болдбаатар: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн энэ төлбөр бол яг улсын төсөвт төвлөрөөд явж байгаа. Улсын төсөвт төвлөрч байгаад оны эцэст бол яг нөгөө хуулийнхаа дагуу бол нөгөө Байгаль хамгаалах сандаа төвлөрөөд тэндээсээ бол 50 хувь нь цэвэрлэх байгууламж, 50 хувь нь бусад зардлаар ингэж эргэн зарцуулагдах ёстой. Тэгэхээр зэрэг улсын төсөвт төвлөрсөн энэ хаягдал усны төлөвлөгөө нь байгаль хамгаалах сан руугаа шилжих энэ зохицуулалт нь бас зөрчилтэй байгаа учраас энэ рүүгээ шилжиж орохгүй байгаа. Энэнээс үүдээд нөгөө зарцуулалтаа бид нар бол. Энэ дээр бас татвараас боломжтой санал хэлэх болов уу?

Б.Саранчимэг: Нэг номерын микрофоныг өгье.

Н.Мөнхдаваа: Сайн байцаана уу? Татварын ерөнхий газрын татварын удирдлага олон улсын татварын газрын татварын улсын ахлах байцаагч Мөнхдаваа байна.

Татварын алба нь бол Ус суваг, усны газрын ногдуулсан нөгөө ус бохирдуулсны хяналт шинжилгээ үнэлгээ хийгээд одоо төлбөрийг нь бол тооцож нөгөө ногдуулаад тэр ногдлынхоо мэдээллийг татварын албанд ирүүлснээр бол ус бохирдуулсны төлбөрийг бол хурааж байгаа.

Одоогийн байдлаар усны газартай манай татварын алба нь бол хамтарсан мэдээлэл харилцан солилцох үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор нөгөө мэдээлэл харилцан солилцож байгаа. Цахимжуулах чиглэлээр бол

хамтран ажиллаж байна. Үүний дагуу бол 2021 оны Байгаль орчны сайд болон Сангийн сайдын хамтарсан ус бохирдуулсны төлбөрийн хувь хэмжээ тогтоох тухай тушаал гарсны дагуу, хамтарсан тушаалын дагуу бол илүү ус бохирдуулсны төлбөрийн тайланг гаргахад тайлагнахад бол илүү хялбар байлгах үүднээс бол татварын тайлан ирүүлэх үйл ажиллагааг бол хялбаршуулан цахим болгож илүү хялбараар тайлангаа гаргах байдлаар бол үйл ажиллагаагаа боловсронгуй болгон ажиллаж байна. Ус бохирдуулсны төлбөрийн төлөлтийг нь бол орлогын талыг нь манай татварын алба бол хурааж байгаа хэдий ч зарцуулалт талыг нь бол Сангийн яам хариуцаж ажиллаж байгаа. Зарцуулалтыг бол манай татварын алба мэдэхгүй байгаа юм аа.

Б.Саранчимэг: Түрүү жил бид нар яг хэлэлцэхэд яг л энийг л ярьж байсан. Өнөөдөр яг нөгөө төвлөрсөн мөнгөө зориулалтын дагуу зарцуулж чадахгүй байна, ямар нэгэн зөрчилтэй байна гэдгийг бас Усны газрынхан ярьж байсан. Тэгээд дахиад л бахь байдгаараа ингээд ярьж байна. Харамсалтай байна. Ямар ч гэсэн Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асуучих. Би дараа нь тодруулж асууна.

Ж.Бат-Эрдэнэ: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт гээд ерөнхийдөө тайлбараар чинь бол хэрэгжилт нэг их сайнгүй байгаад байгаа юм байна шүү дээ. Тэгэхээр 1 дүгээр асуулт энэ түрүүн та нар хэллээ. Энэ 2021 онд 16.34 тэрбум төгрөг гээд. Гэтэл энэ жил бол юу билээ? 3.8 тэрбум. Тэгээд яг юунаас болсон гэдгээ нэг тодорхой бас хэлэхгүй л. Яагаад байх юм ямар ямар байгууллагууд байгаад байгаа юм яагаад өгөхгүй болчихоод байгаа юм гэсэн тиймэрхүү юмнууд, 1 дүгээрт.

Хоёрдугаарт хэрвээ өгөгдөхгүй байгаад байгаа бол төлбөр төлөгдөхгүй байгаа бол нэг бол та нар авахгүй байгаад байна. Нэг бол энэ чинь өөрөө хууль чинь зөрчилтэй байгаад байна гэсэн үг шүү дээ. Тэгэхээр хууль чинь зөрчилтэй байна уу

гэдэг тийм асуулт л асуумаар байгаад байгаа юм. Энэ хууль чинь яг болж байгаа юм уу? Амьдрал дээр.

Тэгээд ингээд л хэдүүлээ яах юм зүгээр хүрч ирээд л нөгөө гоншигноно гэж ярьдаг шүү дээ. Та бүхэн бид нар төлбөрөө ав усаа бүү бохирдуул гэдэг. Та нар болохоор хууль гаргачихсан болж байна бид нар гээд. Бид нар хуулийн хэрэгжилтийг та нараас нэхээд байдаг. Та бүхэн болохоор орж ирчхээд хууль болж өгөхгүй байна гээд байгаа юм уу эсвэл одоо бид нар авч чадахгүй байна гээд байгаа юм уу бас л ийм гомдол янз янзын юм яриад сууж байх юм.

Тэгэхээр 2 дахь асуулт бол ерөөсөө яг энэ хууль чинь хэрэгжиж байгаа юм уу үгүй юм уу? 3 дугаар асуулт одоо энэ Хан-Уул дүүргийн Био комбинат, Шувууны чиглэлийн тэр Туул гол чинь маш их бохирдолтой байгаа тэ? Энийг мэдэж байгаа юу? Яг ямар хэмжээний бохирдолтой байгааг надаа нэг хэлээд өгөөч. Өмхий үнэртэй л байгаа шүү дээ ер нь бол бохирдолтой. Тэгэхээр энийг хэн хариуцах ёстой юм. Тэр ААН-үүд бохироо гаргаж ирж байгаа ААН-үүд хариуцах ёстой юм уу эсвэл бохирыг нь дутуу цэвэрлэсэн харгиа хариуцах ёстой юм уу? Энэ дээр нэг тодорхой тэгээд дахиад би лавлая хариулт өгөөч.

Б.Саранчимэг: Усны дарга Болдбаатар дарга хариулъя. 4 номер.

Я.Болдбаатар: Сая Бат-Эрдэнэ гишүүн хэллээ. Яг одоогийн мөрдөгдөж байгаа Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн дагуу бид нар бас төлбөр мөнгөө тооцоод тэгээд төлбөрөө аваад явж байгаа. Гэтэл энэ маань бас тодорхой хэмжээнд бас түрүүчийн ярьдгаар ингээд иргэн зарцуулагдах нөхцөл энэ тэр бүрдэхгүй байгаа учраас Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульдаа дахин шинэчлэх нэмэлт оруулах чиглэлээр бол бас ажиллаж байна. Энэ дээр бол Саранчимэг гишүүн маань өөрөө бүр ажлын хэсгийн гишүүнээр ингээд ажиллаж байгаа. Тэгээд энэ хуульдаа

одоо энэ шинэчилж байгаа энэ нэмэлт тодотгол оруулж байгаа энэ хуульд саяын энэ зөрчилтэй байгаа гацаад байгаа зүйл заалтуудыг бол шинэчилж оруулахаар ингээд бид нар үзэл баримтлал бүх юмаа боловсруулаад БОАЖЯ-даа өгчихсөн. Ингээд явж байгаа.

Дараагийнх нь Туул голтой холбоотой. Энэ дээр бол яг цэвэрлэх байгууламжийн хувьд бол Төв цэвэрлэх байгууламж маань Ус сувгийн харьяаны ингээд цэвэрлээд явж байна. Энэ Ус сувагтай бид нар маш олон удаагийн уулзалт энэ тал дээр ярьсан. Тэгэхээр зэрэг Ус суваг маань өөрөө бас яг энэ ус хүлээж авч байгаа бохир хүлээж авч байгаа байгууллагууд аж ахуйн нэгжүүд дээрээ бас яг хяналт тавиад ингээд явах бас бид нарт бас тэр үүрэг функц нь байдаггүй ээ. Бид нар зөвхөн цэвэрлэх үүрэгтэй гэдэг төлбөр тооцоон дээр бас хэлдэг. Манайх тэр төлбөр тооцоог бол бид нар цуглуулж ингэж бөөгнүүлж авах бас тийм боломжгүй ээ гэдэг бас тийм нөхцөлийг бас урдаас хэлдэг.

Тэгэхээр энэ дээр бол бид бүхэн бас цаашидаа бас хуульдаа бас тодорхой хэмжээний бас өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай байна гэж үзэж байгаа юм.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ гишүүн тодруулъя.

Ж.Бат-Эрдэнэ: Нэг дүгээрт бол энэ төлбөр чинь яг яагаад доошоогоо орчхоод байгаа юм бэ? 16 тэрбум чинь 3 тэрбум руу яг яагаад орчхоод байгаа юм бэ гэдгийг нэг тайлбарлаад өгөөч, нэг.

Хоёрдугаарт тэр харгиа нь буруутай юм уу эсвэл нийлүүлж байгаа бохироо нийлүүлж байгаа компаниуд буруутай юм уу? Энд тодорхой хэлээд өг л дөө. Эсвэл дутуу цэвэрлэж байгаа харгиа чинь буруутай юм уу гээд байна шүү дээ.

Гуравдугаарт энэ хууль чинь яг юу нь болохгүй байгаад байгаа юм бэ гээд

хэлээд өг л дөө. Хуульд өөрчлөлт оруулах гэж байгаа яг юу нь өөрчлөлт оруулах гээд байгаа юм. Юу нь болохгүй болоод хуульд өөрчлөлт оруулах гээд байгаа юм.

Б.Саранчимэг: 2019 онд анх нэмэлт, өөрчлөлт оруулалт хийж би яг энэ хуулийн ажлын хэсгийг ахалж бас батлуулж байсан.

Тэгэхээр энэ хууль батлагдсанаараа өнөөдөр Монгол Улсад бас 350 сая долларын буцалтгүй тусламж тэр усны асуудлыг бас нэлээн шийдэхэд маш том хөрөнгө оруулчихсан байгаа. Тэгээд яг тодорхой асуулт асуугаад байна шүү дээ.

Өнөөдрийн энэ хууль чинь хуримтлагдаж байгаа мөнгө чинь улсын төсөвт орж байгаа тэгээд дахиад түрүү жил болоход түрүүний жил бас хэлэлцээд явж байхад дахиад тэр мөнгөө авч чадахгүй зарцуулж чадахгүй болчихсон л байсан. Эргээд энэ чинь яг хэвээрээ байна шүү дээ. Тэгээд энийг Засгийн газар өөрсдөө хоорондоо яриад энэнийхээ шийдлийг нь гаргаж явахгүй бол болохгүй байгаа. Тэгээд дээрээс нь 2021 онд анх хууль батлагдсаны дараа 16 тэрбумыг хуримтлуулж байсан бол өнөөдөр 3 тэрбум гаран болчихсон. Тэгээд өнөөдөр усны бохирдол бас ямар хэмжээнд байгаа билээ. Тэгээд Болдбаатар дарга өөрөө яг энэ усны асуудлыг хариуцаж байгаа юм бол бас ажлаа мэддэг хариуцсан шиг хариуцаад явах шаардлагатай байна шүү дээ. Тэгээд гишүүд их тодорхой асуугаад байна.

Дахиад Бат-Эрдэнэ сайдын гишүүний асуултад хариулаадаа даа. 4 номерын микрофоныг өгье.

Д.Мөнхзул: Харгиа цэвэрлэх байгууламж нь ажиллахгүй байна уу? Ус сувгийн төв цэвэрлэх байгууламж ажиллахгүй байна уу? Эс үгүй бол аж ахуйн нэгжээс болж байна уу гээд. Энэ дээр бол өмнө нь аж ахуйн нэгжээс ер нь бол бид нар УСУГ-ын Төв цэвэрлэх байгууламж, Харгиа цэвэрлэх

байгууламж 2 яг ашиглалтынхаа горимдоо ажиллаж чадахгүй цэвэрлэхгүй байгальд шууд нийлүүлж байна гэж харж байгаа.

Ингээд эд нар цэвэрлэхгүй байгаа болохоор аж ахуйн нэгжүүд өндөр бохирдолтой тэгээд их хэмжээний ус нийлүүлээд байна. Ингэхээр бид нар ачааллаа дийлэхгүй ажиллаж байгаа болохоор ингээд хаягдал бохир усыг цэвэрлэхгүй шууд хаяад байна гэж УСУГ-аас мэдэгдэж байгаа. Гэтэл бид нар Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлж эхэлснээр хаягдал усны дүгнэлтээр дамжуулаад аж ахуйн нэгж байгууллагыг заавал урьдчилан цэвэрлэх байгууламж суурилуулаад тэр MNS 6561 ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал бохир ус стандартын шаардлагыг хангасан усыг та нар Ус сувгийн цэвэрлэх байгууламж руу нийлүүлээдхээч ээ. Тэгэх юм бол Ус суваг ч.../минут дуусаа/.

Б.Саранчимэг: Би бас энэ гишүүдтэй санал нэг байна аа. Тэгэхээр энэ дээр би бол бас дахиад энэ асуултуудыг бас нэгтгээд яг нэг тодорхой асуулт асуугаадахъя. Тодорхой хариултаа өгөөч ээ. Түрүү жил бид нар яг энэ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хэлэлцэж байсан. Нэлээн олон асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгаа гэсэн. Тэгэхээр яг ямар ахиц гарсан бэ? 1 дүгээр асуулт.

Хоёрдугаарт бол яам агентлагаас энэ бохир усны тоолуур суурилуулаагүйгээс хаягдал усны төлбөргүйг зөв тооцохгүй байгаа гомдол гараад байгаа. Тэгэхээр энэ асуудлыг яаж шийдвэрлэж байгаа вэ?

Гуравт, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжүүлэх гол ажил бол усны бохирдлын шинжилгээ хийж бохирдлын түвшнийг тогтоох ажил байгаа. Тэгэхээр орон нутагт усны шинжилгээ хийх лабораторын хүчин чадал байхгүй мөн хангалтгүй байгаа хүнд металлын бас үзүүлэлтийг үзэж

чаддаггүй, боловсон хүчин байхгүй гээд байгаа. Энэ тал дээр яг ямар ажил зохион байгуулж байгаа вэ? Хэзээ тэр нөгөө хуримтлагдсан мөнгөө зориулалтаар ашиглах вэ? Нөгөө талаар бол энэ бид нар Мянганы сорилтын корпорацын 2 дугаар компакт гэрээний хүрээнд энэ цэвэрлэх байгууламжаас гарах 50 мянга гаран метр куб энэ усыг боловсруулж мөн энэ дулааны 3, 4 дүгээр цахилгаан станцын техникийн хөргөлт ашиглана. Мөн усыг дахин ашиглах асуудлыг шийднэ гээд. Тэгээд 2013 оны бохирдлын хэмжээнд хүргэнэ гэсэн ийм зорилт тавьчихсан байгаа. Одоо яг ямар байгаа вэ? Тэгээд яг энэ 4 асуулт дээр нэг тодорхой хариулт өгөөч.

Бат-Эрдэнэ гишүүн бас нэмээд тодруулъя гэж байна.

Ж.Бат-Эрдэнэ: Та хэдийн хариултаас хараад байхаар чинь ерөөсөө наад гаргалгаа гарцаа ерөөсөө олж харахгүй яваад байгаа юм биш үү? Тойрч давхиад л байх юм. Үгүй ээ байгаль орчинд бохир ус гаргаж байгаа бол тэр бохир усыг шүүгээд цэвэрлэх үүрэгтэй тэр харгиа нь байна уу? Төв цэвэрлэх байгууламж чинь өөрөө буруутай юм биш юм уу? Тэгэхээр тэр байгууллага дээрээ арга хэмжээ авахгүй юм уу? Тэр байгууллага дээрээ хөрөнгө оруулалт оруулахгүй юм уу? Би энийг чинь л хамгийн эцсийн гаргалгааг чинь хэлүүлэх гээд байгаа байхгүй юу даа. Тэр цэвэрлэх байгууламж үнэхээр чадахгүй байна. Тийм болохоор байгаль орчин бохирдуулаад байна бид нарт мөнгөө өгөхгүй байна. Тийм болохоор энэ дээр хөрөнгө оруулалт оруулъя. Тэгээд одоо Байнгын хорооноос эсвэл тэр арга хэмжээнүүд аваад тэр Засгийн газар хөрөнгө оруулалтаа оруул гэсэн үүрэг даалгавар өгүүлээд. Хэрвээ та нар чаддаггүй юм бол. Энэ гаргалгааг чинь хэлүүлэх гээд л би наад асуултыг чинь асуугаад байна шүү дээ. Эцсийн эцэст энэ чинь байгаль бохирдуулсныхаа төлбөр л гэж байгаа юм бол бохирдуулж байгаа байгууллага дээрээ тооцох ёстой юм байгаа.

Б.Саранчимэг: Бат-Эрдэнэ сайд эхлээд хариулах уу? Дараа нь тэр харьяаны хамгийн гол хариуцах хүмүүс чинь энэ агентлагийн хүмүүс шүү, ус хариуцаж байгаа хүмүүс шүү. Тэгээд нэг даалгавар өгдөг дараа нь нөгөө ингээд сайд нь сайддаа буруу зөв мэдээлэл өгөөд байдаг. Тэгээд яг хэрэгжиж байгаа асуудал нь яг ямар байна гээд тэгэхээр бас л асуудалтай байгаад байдаг.

2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя.

Төв цэвэрлэх байгууламжийн ялангуяа энэ Туул голтой холбоо бүхий асуудал дээр бол усны чанарын индексээр маш бохир ангилалд орж байгаа. Сая бид нар 3 дугаар сард Усны үндэсний чуулган хийсэн. Энэ чуулган дээр бол Туул голын бохирдол Туул голын сав дагуух хог хаягдлын асуудлууд тухайн үйлдвэртэй холбоотой. Жишээлбэл арьс ширний үйлдвэр дээр бид нар тодорхой хэмжээний бас хяналт шалгалтын үйл ажиллагаануудыг хийсэн. Туул голд Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлсэн ус Туул голд нийлүүлснээс доош голын усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламжийн стандартаас 2.3-аас 60.6 дахин их гарч байгаа. Таны яг түрүүний асуусан асуултын дагуу яг тодорхой хариулахад. Эрдэс фосфор стандартаас 17.4-өөс 56.4 дахин их гарч байгаа, аммоны азотын агууламж өвөл хаврын улиралд 3-аас 76 дахин нийтийн агууламж стандартаас 1.6-аас 17.7 дахин тус тус давсан үзүүлэлттэй гарч байгаа. Энэ бол маш их бохирдолтой гарч байгаа гэсэн үг.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам гээд ингээд 3 яамны хамтарсан ялангуяа энэ 3 сайдын хамтарсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар холбогдох яамдуудад хүргүүлсэн. Ялангуяа саяын яригдаад

байгаа буюу энэ Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 7 дээр Байгаль орчин уур амьсгалын сангийн холбоо бүхий асуудлыг тусгаж өгсөн байдаг. Ялангуяа тухайн сангаас зарцуулагдах ёстой мөнгө юунд зарцуулагдах ёстой вэ гэдэг зориулалт. Энэ зориулалт дээр бол бид нар нэмэлтээр цэвэрлэх байгууламжийн шинэчлэл засвар үйлчилгээнд зарцуулагдах байгаль орчны лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэхэд зарцуулагдах гэдэг. Энэ 2 нэмэлт өөрчлөлтийг бол Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар оруулж байгаа.

Өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд уул нь бол ус бохирдуулсны төлбөрөөс орж байгаа орлого маань өөрөө энэ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.3-аар Байгаль орчин уур амьсгалын санд төвлөрч байх ёстой. Төвлөрсөн мөнгөнөөс ус усны нөөцийг хамгаалах, усны бохирдлыг арилгах, хяналт шинжилгээ хийх, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах ба орлогын 50-аас доошгүй хувийг цэвэрлэх байгууламжид шинэчлэл үйлчилгээний засвар үйлчилгээнд зарцуулах ёстой гэдэг ийм заалттай.

Миний нөгөө түрүүний хэлээд байгаа Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль хэрэгжихгүй жишээлэх юм бол 2021 онд 149.9 тэрбум төгрөг төвлөрчхөөд байхад гүйцэтгэл нь 20 хувь хүрэхтэй үгүйтэй байсантай л холбоотой бас. Сангийн яам илүү тодорхой хариулах ёстой болов уу гэж бодож байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулиар төвлөрсөн орлого нь байгаад байдаг. Тэр орлого нь өөрөө Байгаль орчин уур амьсгалын сан руугаа ордоггүй. Ийм асуудлууд байгаад байгаа юм. Түрүүний таны хөндөөд байгаа яагаад 39 тэрбум 17 тэрбум байгаад байгаа мөртөө яагаад 3.9 болчихоод 3.8 тэрбум төгрөг болчихоод байгаа юм бэ гэхээр энэ 3.8 нь бол зөвхөн Ус сувгийн удирдах газартай ч холбоотой

бас биш. Энэ 2020, 2021, 2022 гээд ингээд тооцооллуудыг нь бүгдийг нь ингээд тэрбум төгрөгөөр нийт үнэлгээг нь ингээд гаргаад үзэхээр ноогдуулсан төлбөрийн хэмжээ нь өөрөө 39 тэрбум төгрөг хүрчхээд байгаа юм. 39 тэрбум төгрөгийг төлөх ёстой. төлөх ёстой. Энэ бол байгаль орчин усыг бохирдуулсантай холбоотой. Зөвхөн энэ дотроос гэхэд 17.7 тэрбум төгрөг нь Ус сувгийн удирдах газартай холбоотой төлбөр болчихоод байгаа юм.

Тэгэхээр энэ дээр бол тэр төвлөрөөд байгаа 3.8

Б.Саранчимэг: Нэмж хариулах уу? 2 номерын микрофоныг өгье.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр 39 тэрбум төгрөг бол 3 тэрбум төгрөг болж багасчхаад байгаа юм биш. 39 тэрбум төгрөг төвлөрөх ёстойгоос 3 тэрбум төгрөг л төвлөрчхөөд байгаа гэсэн үг болоод байгаа юм.

Өөрөөр хэлбэл 10 хувь хүрэхтэй үгүйтэй хэмжээний мөнгө л төвлөрсөн. Бусад мөнгө нь. Энэ улсын төсөв рүү л шууд орж байгаа юм. Татварын байгууллага л төвлөрүүлж байгаа шүү дээ. Татварын байгууллага л төвлөрүүлж байгаа юм. Төлбөрийг хэн төвлөрүүлсэн бэ гэж үү? Аж ахуйн нэгжүүд л төвлөрүүлж байгаа юм.

Б.Саранчимэг: Яг энэ асуудлыг би бас Болдбаатар даргыг илүү хариулаасай гэж хүсэж байгаа байхгүй юу. Та нар яг энэ усны асуудал хариуцсан агентлаг байна газар байна. Та нар яг энийгээ өөрсдөө бас тэр мөнгөө төвлөрүүлэх өөрсдөө энэ хууль, эрх зүйн орчныг нь өөрчлүүлэх юмыг одоо бас энэ Засгийн газрын хоорондох хэмжээнд бас сайдаа ойлгуулаад энэнийхээ төлөө явах хэрэгтэй байна. Дахиад одоо бахь байдгаараа ингээд жилийн өмнө ярьж байсан шигээ баймааргүй байгаа байхгүй юу.

Тэгэхээр Мягмар даргын үед бас энийг хэлээд л байсан. Тэгээд дахиад л

яригдаад ингээд явж байна. Тэгэхээр Болдбаатар дарга бас эрчтэй яг энэ дээрээ илүү их анхаараад ойрын үед бас яг энэ хууль, эрх зүйн орчин сайжруулах тэр зөрчил дээр Засгийн газрын хоорондох зөрчлөө арилгаад тулгамдаад байгаа асуудал дээрээ эргээд Байнгын хороонд бас нэг мэдээлэл өгөх хэрэгтэй байна. Энэнтэй холбогдуулаад өнөөдөр бид нараасаа протоколоороо үүрэг даалгавар өгнө өө.

Тэгээд манай гишүүд үг хэлнэ.

Үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Идэрбат гишүүнээр тасаллаа.

Бат-Эрдэнэ гишүүн саналаа хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Нэг их айхтар асуулт асуухгүй гэж байсан. Тэгээд та хэд чинь өөрөө энэ ажлаа мэдэж байгаа мэдэхгүй нь мэдэгдэхгүй болоод бүүр улам өөр өөрсдийгөө барьж өгөөд байх юм. Энэ бараг л ч урд талынх нь тэр Мягмар нь ч илүү байсан юм уу гэхээр сэтгэгдэл төрж байна шүү дээ. Олигтой ч хариулахгүй юмнуудаа ингээд л тойрч давхиад л байх юм. Ер нь бол шинэ ч бай хуучин ч бай тэгээд бид нар нэг тэгээд одоо нэг ажилдаа нэг сайхан сураарай ажилдаа дадаарай гэж байдаг юмнаасаа больчих хэрэгтэй байна шүү дээ. Чаддаг хүнийг нь авч ирж тавих хэрэгтэй байна шүү дээ. Заавал хүн авчирч тавьж байж ингэж хүмүүжүүлж, ингэж юманд сургаж, дадал үүсгэж байх ямар хэрэгтэй байдаг юм?

Энд шууд гарцуудаа яриад явчихмаар байгаа байхгүй юу даа. 39 тэрбум төгрөг орж ирэхээс 3.9 тэрбум төгрөг нь орчихсон байгаа юм байна. Сая надад хариулснаар аж ахуйн нэгжүүд л хөөрхий нөгөө хувийн аж ахуйн нэгжүүдээ та нар чаддагаараа дарамтлаад л өгчихсөн гэж л ойлгох гээд байна шүү дээ. Ер нь тэгж л харагдаж байгаа юм. Тэрний цаана харгиа юу байдаг юм тэр Улсын үйлдвэрийн газар Улаанбаатар хот болон бусад улсын үйлдвэрийн газрууд нь бол өгдөггүй гүрийчихдэг. Яг л тийм

байдал харагдаад байна шүү дээ. Тэгвэл наад хуульдаа өөр зүйл оруул л даа. Хоорондын тооцоогоор дандаа ингээд явж байдаг улсад болохоор юмнуудаа төлдөггүй, хуульд болохоор төлөх ёстой гээд заачихсан байдаг. Тэгээд энд ингээд нүүрээ улайлгаад сууж байхаар наад хуульдаа оруулаад ямар нэгэн гарцууд олох хэрэгтэй байхгүй юу. Болохгүй бол тэр жил болгоны Сангийн яамны төсөв дээр суулгаж байдаг ч байдаг юм уу ийм гарц юмнуудаа хуульд оруулаад ингээд явах хэрэгтэй байхгүй юу даа. Одоо тэгээд яг наана чинь бол хувийн аж ахуйн нэгжүүд чинь л өөрсдөө төлбөрөө төлөөд л явж байна шүү дээ. Чаддагаараа нөгөөдүүлийгээ л дарамталж байгаа.

Тэгэхээр ерөөсөө би та нараас юу хүсээд байна гэхээр төрийн ажил хийж байгаа бол гарц гаргалгаануудаа хэлээд яг ийм ийм учиртай юм гэдэг юмнуудыг чинь гаргаад би гаргалгааг чинь ядаж хармаар байна шүү дээ. Ямар гаргалгаа байх ёстой юм. Эсвэл магадгүй та нарын зовлон жаргалыг чинь сонсож байгаад өшөө гаргалгааг нь хэлж өгмөөр байгаад байгаа байхгүй юу даа. Тэр гаргалгаануудаа чи ерөөсөө гаргаж ирэхгүй байна шүү дээ. Та нар чинь бөөн л зовлон л яриад байх юм. Тэгээд хамгийн гол нь төлбөр. Нэгэнт Төлбөрийн тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль байгаа бол ямар ямар байгууллагууд яаж бохирдуулаад байгаа юм тэрэнд гарч байгаа төлбөрөө яаж авах юм гэдэг схем чинь хамгийн гол чухал байгаад байна шүү дээ. Тэгээд цаашаа авсан мөнгөө юу юундаа зарцуулах юм? Мэдээж дандаа хөрөнгө оруулалт оруулах байх. Улсын үйлдвэрийн газрууд байгаа бол тэрний хөрөнгө оруулалтуудыг сайжруулах хэрэгтэй байдаг байх.

Цааш цаашдын хуулийнх нь нэг гол гол юм зүйлүүдийг би сайн мэдэхгүй юм. Тэгэхээр ийшээгээ ингэж асуудал болгож оруулж ирж байгаа юм чинь та нар бол буцаад нөгөө нэг бөөсний үлгэртэй адилхан ярианы чинь хэлбэр юмнууд чинь дандаа гаргалгаанууд байгаа, гарц руугаа орж ирээд байвал энэ чинь төрийн ажил

хийж байгаагийн чинь ганц гаргалгаа үүрэг чинь бол тэр шүү дээ уг нь бол. Тэр талаасаа л энэ юмнуудаа хармаар байгаа юм. Ус гээд түрүүн хэллээ шүү дээ. Ус чандмань эрдэнэ гээд бид нарын хувьд бол усны асуудал чинь маш өндөр тавигдаж байгаа шүү дээ. Улам цаашаагаа явах тусмаа улам өндөр болно. Тэгэхээр энэ бохирдуулж байгаа асуудал дээрээ бид нар чанга байж байж усаа хэмнэдэг байх ёстой. Усаа буцаад саарал болгодог байх ёстой буцаад дахин ашигладаг байх хэрэгтэй. Бага ашигладаг болгох хэрэгтэй ч гэдэг юм уу, хэмнэдэг байх ёстой ч гэдэг юм уу гол асуудлын чинь хууль чинь энэ дотор байж байгаа шүү дээ. Энэ төлбөр чинь авагддаг л байвал энэ төлбөртөө баригдаад хэмнэдэг цэвэрлэдэг бүх схем рүүгээ орж таарна шүү дээ. Тэгэхээр чинь түлхүүр чинь энд байгаад байгаа байхгүй юу. Уг нь бол. Баярлалаа.

Б.Саранчимэг: Болорчулуун гишүүн саналаа хэлье.

Х.Болорчулуун: Миний хэлэх гэсэн захиасыг Бат-Эрдэнэ гишүүн өгчихлөө л дөө. Уг нь бол энэ Болдбаатар дарга усны гидрогеологич мэргэжилтэй юм байна. Энэ асуултуудад дандаа тойруу замаар шууд хариулахгүй байхаар нь гайхаад ямар мэргэжилтэй юм бэ гээд асуусан чинь гидрогеологич юм байна. Ажлаа ер нь өөрийн болгож яамандаа болон сайдыгаа сайн цэнэглэж байгаарай. Сайд гэдэг хүн бүхнийг мэдэх хүн биш шүү дээ. Та нар доороос нь асуудлыг бол ажлыг үнэн зөвөөр нь өөрийн болгож мэдээллээ өгч байх ёстой. Ер нь ингээд харж байхад ус бохирдуулсны төлбөрийг бол их бага хувиар авч байна гэж байна. Төлөвлөгөөнөөсөө энэ бол зөвхөн татварын газрын асуудал биш. Одоо бол мэргэжлийн хяналт татан буугдаад салбарын хяналт яам яаман дээр очсон болохоор бас энэ байцаагч нар бас давхар мэдээж хяналт тавих байх гэж бодож байна. Тавьж ажиллах ёстой. Зөвхөн 2022 онд гэхэд ус бохирдуулсны төлбөрт 5.4 тэрбум төлөвлөөд чөлөөлөгдсөн нь бол 3.9 тэрбум. 80 хувь нь чөлөөлөгдсөн байх жишээтэй.

Тэгэхээр ус бохирдуулсны төлбөрийн авалт яг улсын төсөвт оролт энэ тэр их л бага л байна л гэж харагдаж байна л даа.

Тэр компаниуд нь бол ялангуяа уул уурхайн компаниуд яг эргэж саарал ус ашиглах нь хэр байдаг юм бэ дээ? Тоон мэдээллээр худлаа ашигласан гэж өгдөг юм биш биз дээ? Би энэ дээр бас нэгэнт усныхан ярьсны энэ зарим компани Оюу Толгой энэ тэр бол үнэхээр харамсалтай бага усны төлбөр төлдөг. Өнгөрсөн 12 сард 900 байснаа 1600 болсон 1м³ ус. Гэтэл олон улсад бол 1-ээс 3.5 долларыг метр куб усанд төлдөг.

Тийм учраас би бол энэ дээр бас чиглэл болгоод өгөх хэрэгтэй гэж бодож байна Байнгын хорооноос. Яах вэ нэг компани нэр заагаад утгагүй. Тэгэхээр олон улсын гэрээтэй экспортод бүтээгдэхүүнээ доллар гаргадаг, татварын хөнгөлөлт, тогтворжуулалтыг гэрээгээр эдэлдэг ийм компаниудад олон улсын жишиг дунджаар ус ашигласны төлбөрийг авах ёстой гэсэн чиглэлийг хэрэгжүүлэхийг яаманд даалгамаар байна аа.

Бид 0.5 цент ч хүрэхгүй байна шүү дээ. Тэгэхэд 1-ээс 3.5 доллар байдаг олон улсын жишиг нь тийм биз дээ Болдбаатар дарга аа? Тийм тэгэхээр бид нар олон улсын жишигээр авах ёстой. Яахаараа бид нар авах юмаа авч чадахгүй тэгээд байгалийн баялгийгаа тэр алт зэс ч борлуулна эргээд Монголбанкаар дамжихгүй ингэж дээрэмдүүлж байдаг юм. Ядахдаа усныхаа төлбөрийг жишигт дөхүүлж авмаар байна шүү дээ. Энэ дээр ажиллаасай гэдэг чиглэл болгож өгье.

Б.Саранчимэг: Баярлалаа. Тэгэхээр өнөөдрийн хурлаас бид нар яг протоколоор үүрэг даалгавар өгнө өө. Маши тодорхой саналууд гишүүд хэлж байна. Тэгээд энийг протоколоор оруулна.

Идэрбат гишүүн саналаа хэлье.

Ц.Идэрбат: Ер нь байгаль орчин, уул уурхайтай холбоотой технологийн ус гээд л олон зүйлүүд бас яригдаж байна. Миний хувьд бол энэ төв суурин газрын хэрэглээний ус та бүхний хэлээд байгаа яг энэ саарал усны асуудлаар энэ усны агентлаг маш их санаачилгатай ажилламаар санагдаад байгаа юм. Энэ 330 сум өнөөдөр цэвэрлэх байгууламжтай болж байгаа сумууд нэлээн байна. Халаалтын нэгдсэн системтэй болчихсон нэлээн байна. Цэвэр усны шугамтай болчихсон нэлээн байна. Тэгээд Улаанбаатарт тэрийг эхлүүлэхэд та нарт маш их төвөгтэй тийм суман дээр эхлээд нэг хэрэгжүүлээд үзчихээч ээ. Тэгээд болох болохгүйг нь үзчихмээр байгаа байхгүй юу эхлээд. Дараа нь аймгийн төв дээр наадхаа хийж үзэх хэрэгтэй байгаа юм шүү дээ. Тэгээд та нарынхаар бол одоо MCS-ийн юмыг л яриад суугаад байна шүү дээ. Та нар тэгээд агентлагтай болсны хэрэг юу юм билээ энийг хиймээр байна. Ер нь бид нар яг энэ байгаль орчны салбар дээр нэг очоод Монгол Улсад нэг ийм юм хийдэг энийг нэг цааш нь ингээд дэлгэрүүлчихье гээд үзчих юм хогийн үйлдвэр гэхэд бид байдаггүй.

Би 2017 оноос хойш Монголд хог боловсруулах үйлдвэр юу байна гэж эрж гуйж явсан байхгүй. Өнөөдөр ч байхгүй байгаа болов уу? Утааны асуудал гээд л бас л Улаанбаатарын энэ сая гаруй хүний энэ олон 100 мянган гэр хорооллын утаатай л ноцолдоод байгаа. Эсвэл аймгийн төв дээр утааг яаж бууруулах вэ гэдэг энд зарцуулж байгаа хөрөнгөөс хамаагүй бага хөрөнгөөр зөв шийдлээ гаргаад ирэх юм байгаа шүү дээ уул нь. Би бас сумын дарга байхдаа энийг хэлж л байсан. Тэр хана туургыг нь дулаалаад болох юм уу болохгүй юм уу? Үгүй ээ янз янзын арга өчнөөн хэдэн 10 тэрбум төгрөг шатаагаад л байж байгаа шүү дээ.

Тэгэхээр яг нэг ийм зүйлийг нэг хийгээд эргээд цаашаа цаашаагаа жишиг болоод явчих ийм зүйл рүү орооч ээ. Тэгээд л дандаа Улаанбаатарын жишигээр

яагаад л Улаанбаатарын шугам сүлжээн дундуур тэр саарал усны шугам худлаа шүү дээ, хэцүү, асар их зардалтай. Энд 10 мянган хүнтэй хот ч байж л байна. Бор-Өндөр гээд л байж л байна. Тэгээд ийм газруудад туршаад тэгээд цаашаа дэлгэрүүлээд явах нэг ийм бас нэг санаачилга усан дээр ч гэсэн бусад зүйл дээр бас нэг гаргаач ээ. Одоо аймгийн төвүүд, сумын төвүүд хогоо яахаа мэдэхгүй байгаа шүү дээ. Шатаая аа, шатааж болохгүй, булаад л байгаа, хэдий болтол ч булах вэ. Яг ийм хэрэглээнд таарсан хогийн ямар шийдэл байна вэ? Тийм юмыг бас нэг нэвтрүүлээд өгөөч. Тэгээд 330 суманд тэрийг хэрэгжүүлчихье л дээ гэж ийм л санааг би хэлмээр санагдаад байна.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүнд баярлалаа.

Тэгэхээр Болдбаатар дарга бас энэ ажил руугаа илүү ороод энэ дээрээ бас жоохон эрч хүчтэй ажилламаар байна. Яг эндээс өгөгдөж байгаа үүрэг даалгавруудыг бид нар протоколоор оруулаад явчихна. Тэгэхээр бид нар бас газар дээр нь дараагийн 7 хоногт манай Байнгын хороон дээр яг энэ Мянганы сорилтын сан мөн тэр тодорхой уул уурхай дээр мөн усны яг эх үүсвэрийг хангаж байгаа газрууд дээр очиж ажиллана. Энэ дээр бас яамтай хамтраад ажиллана. Тэгээд цаашидаа бид нар энэ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль батлагдсанаараа өнөөдөр маш үр дүн өгч байгаа шүү дээ. Үнэхээр их бохирдуулж байвал их мөнгө төлнө, мөнгө төлөхгүй гэвэл өөрсдөө өөрийн гэсэн зориулалттай цэвэрлэх байгууламжаа тавь. Ийм л зарчмыг барьж байгаа шүү дээ. Тэгэхээр тийм учраас үнэхээр тэр ус нь бохирдох нь багасаад ингээд мөнгө нь багасчихсан байгаа юу гэдгийг бас газар дээр нь хамтарч ажиллая. Тийм учраас цаашидаа бас энэ дээр яг яг хариуцаж байгаа энэ салбарынх нь хүмүүс илүү их анхаарч бас сайдаа зөв мэдээллээр өгөөд Засгийн газрын хоорондох энэ бас зөрчигдөж байгаа. Улсын төсөвт орлого болж ирж байгаа энэ мөнгийг

зориулалтынх нь дагуу зарцуулах юман дээр та бүгд дараагийн хурлаас өмнө энийгээ яг шийдэл гаргаад биелэлтийг нь танилцуулах хэрэгтэй байна.

Тэгэхээр өнөөдрийн энэ хуралд бүгд бүх гишүүдийн хэлсэн зүйлүүд протоколд орж байгаа учраас энийг даалгавар болгож өгч байна. Тэгээд өнөөдрийн бас хуралд ирсэн ажлын хэсгийнхэндээ баярлалаа.

Тэгээд үүрэг даалгавруудыг яг тодорхой хугацаанд өгөөд явна.

Тэгээд энийгээ бас биелүүлээд яваарай гэж хүсье.

Баярлалаа.

Дараагийнхаа асуудал руу оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Сайдад баярлалаа.

16.09 цагт

Дараагийн хэлэлцэх асуудал.

Байнгын хорооны тогтоолын төсөл цаглавар батлах байгаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороон байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Тэгэхээр энэ тогтоолын төсөл та бүхэнд тараагдсан байгаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу Улсын Их Хурлын дарга 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард хэлэлцэх асуудлын дараалал тогтоох тухай ийм 96 дугаар захирамжийг баталсан. Тэгээд та бүхэнд энэ тогтоолын төсөл тараасан байгаа учраас Байнгын хорооны тогтоолын

төсөлтэй холбогдуулан саналтай гишүүн байна уу нэрсээ өгнө үү?

Гишүүд санал хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийг батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Идэрбат гишүүний микрофоныг өгье.

Ц.Идэрбат: Би сая дэмжиж санал өгсөн. Харамсалтай нь бас төхөөрөмж маань гацаад яалаа. Тэгэхээр энэ удаагийн санал хураалт хүчингүй болгож өгнө үү.

Б.Саранчимэг: Энэ удаагийн санал хураалтыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувиар энэ саналыг хүчингүй болголоо. Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сард Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай Байнгын хорооны тогтоолын төслийн батлахыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

70 хувиар тогтоолын төсөл батлагдлаа.

Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсгийнхнийг оруулаарай.

16.13 цагт

Аймаг дунд отрын бүс нутаг болон бэлчээрийн ашиглалт хамгаалалтын талаар Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын мэдээллийг сонсох байгаа.

Мэдээлэлтэй холбогдуулж ирсэн ажлын хэсгийнхнийг та бүхэнд танилцуулъя. Эхлээд мэдээллийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуун танилцуулъя.

Х.Болорчулуун: Аймаг дундын отрын бүс нутаг болон бэлчээрийн ашиглалт хамгаалалтын талаар Монгол Улсын Үндсэн хуулийн мал сүрэг үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна гэсэн үзэл баримтыг хэрэгжүүлэн мал сүргийг байгалийн давагдашгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хамгаалах зорилгоор 783 мянган га газрыг Засгийн газрын тогтоолоор аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар олон улсын тусгай хэрэгцээнд авсан.

Өнөөдрийн байдлаар Хэнтий аймагт 192.8 мянган га талбайтай. Хэрлэнбаянулааны, Говьсүмбэр аймагт 73.1 мянган га талбайтай Малхын, Завхан аймагт 68.3 мянган га талбайтай Бага хайрхан, Говь-Алтай аймагт 118 мянган га талбайтай Аргалантын, Дорнод аймагт 124.4 мянган га талбайтай Чойбалсангийн, Булган аймагт 34.1 мянган га талбайтай Чилэнгийн, Өвөрхангай аймагт 37.9 мянган га талбайтай Хөх дэлийн, Увс аймагт 28,9 мянган га талбайтай Ачит нуурын, Ховд аймагт 105.2 мянган га талбайтай Баяннуурын отрын бүсийг тус байгуулаад ажиллаж байгаа. Эдгээр аймаг дундын отрын бэлчээрийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан 9 отрын бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг нь манай яамны Аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалтын захиргаа хариуцан ажиллаж байгаа болно.

Отрын бэлчээрийн даац тохирсон малыг жил бүрийн 11 дүгээр сарын 1-ээс дараа жилийн 4 сарын 1-ний өдрийг хүртэл нийт 150 хоногоос хэтрэхгүй хугацаанд нутаглуулах бөгөөд зун намрын улиралд мал оруулахгүй чөлөөлөх арга хэмжээ авч ашиглалт хамгаалалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын 9 отрын бүс нутгуудад 2022 оноос 2023 онуудад 12 аймаг, нийслэлийн 46 сум, дүүргийн 673 өрхийн хонин толгойд шилжүүлснээр 590 мянган толгой мал отрын бүс нутгуудад өвөлжиж хаваржсан. Өнгөрсөн 2022-оос 2023 онд өвөлжилт хаваржилтын хүндэрсэнтэй холбоотойгоор малчид орон нутгийн засаг захиргааны хүсэлтийг харгалзан зөвшөөрөлгүй орсон мал сүргийг бусад нутгуудад өвөлжүүлж хаваржуулсан бөгөөд хаваржилтын хүндрэлтэй байдлыг харгалзан отрын бүс нутгийг малын хөлөөс чөлөөлөх гарах хугацааг тодорхой хугацаагаар сунгаж малчид орон нутгийн захиргаатай хамтран ажилласан.

Аймаг дундын отрын бэлчээрийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах дараах асуудал зайлиггүй шаардлагатай байна. Үүнд Засгийн газрын 2007 оны 187 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын нийтлэг журмыг шинэчлэн батлах, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааг Булган аймгийн Дашинчилэн суманд шилжүүлэн байршуулахаар шийдвэрлэсний дагуу албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа хангах захиргааны үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх материаллаг баазыг нэмэгдүүлэх.

Монгол Улсын нийт бэлчээрийн 10-аас багагүй хувийг улс, орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бэлчээр болгон баталгаажуулж ашиглалт хамгаалалтыг тус захиргаанд хариуцуулах байдлаар захиргааны хамрах хүрээ, эрх зүйн чадамжийг сайжруулах.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан орон нутгийн тусгай хэрэгцээний отрын бэлчээрийн хэмжээг нэмэгдүүлэхэд Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа хамтран ажиллах эрх зүйн боломж бүрдүүлэх зэрэг ажлуудыг хийх болно.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайдад баярлалаа.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж ирсэн ажлын хэсгийнхнийг та бүхэнд танилцуулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Болорчулуун мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, мөн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Наранчулуун, яамны Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Довчинсүрэн, Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргааны Хууль эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Эрдэнэбаяр.

Түрүүний Байнгын хорооны хурлаар яг нөгөө сайд байгаагүй. Гэхдээ манай гишүүд яг энэ асуудлаар бас мэдээлэл сонсёе гээд санал ирүүлсэн. Тийм учраас энэ асуудлыг бас өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцүүлж байгаа.

Тэгэхээр хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Мөнхцэцэг гишүүнээр тасаллаа.

Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Энэ асуудал бас нэлээн нухацтай ярихгүй бол ийм товчхон хүрээнд ингэж яриад эд нар бас шийдэгдэхгүй болчихсон асуудал аа. Энэ Байнгын хорооны хурал дээр бас ингэж энэ тавьсан саналыг бас ажил хэрэг болгож өнөөдөр ингэж энэ асуудлыг ярих бололцоог олгосон Байнгын хорооны даргад бас баярлалаа гэж хэлье.

Ер нь энэ аймаг дундын отрын бүс нутаг 1960-аад оноос байгуулагдсан. Тэр үед нэгдэл, нийгэм Монгол Улсын эдийн засаг бодлого шал өөр байсан. Өнөөдөр ямархуу түвшинд байгаа билээ. Тэгэхээр анх байгуулагдсан тэр зорилгоор өнөөдөр

9 газар энэ отрын бүс нутаг байгуулаад ингээд явж байгаа нь ер нь цаашидаа ер нь хэр оновчтой гэж ингээж үзэж байгаа юм бэ? Хууль эрх зүйн орчин ямар байгаа вэ гэхээр энэ алсын хараа, дунд хугацааны хөгжлийн бичиг баримт дээр бэлчээрийн газрыг сайжруулах ашиглах гэсэн л ийм зүйлүүд байгаа болохоос биш яг отрын бүс нутаг гэсэн юм бас байхгүй шүү дээ. Тэгээд би ямар эрх зүйн үндэслэл гаргаж ирэх юм бол гэсэн чинь ийм эрх зүйн үндэслэл гаргаж ирж байна лээ. Энэ отрын бүс нутаг биш байхгүй юу. Харин зүгээр одоо талхлагдчихаад байгаа 63 хувийн бэлчээрээ цөлжчихөөд байгаа 17 хувийн бэлчээрээ яах вэ л гэдэг асуудал байгаа болохоос биш отрын бүс нутгаар ер нь юу шийдэх гээд байгаа юм гээд би гайхаад.

Отрын бүс нутаг дээр сайд өөрөө очиж үзсэн. Нөхцөл байдал ер нь ямархуу байдалтай байгаа вэ гэдгийг нэлээн сайн харсан. Шинэ дарга бол саяхан нэг хэдэн малчин эргээд явж байна гэсэн сураг байсан. Сум орон нутгийнхантай огт уулзаагүй явсан байна лээ. Энэ отрын бүс нутгийн бэлчээрийн даац энэ нөгөө ургамлын зүй тогтоц бүх юмнууд чинь ер нь алдагдчихаад байгаа гэдгийг ер нь та бүхэн мэдэж байна уу, үгүй юү. Өнөөдөр гэхэд энэ дээр сая их сайхан юм ярьж байна л даа. 11 сарын 1-нд ороод 4 сарын 1-нд 150 хоногоос хэтрэхгүй. Өнөөдөр Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан аймаг дундын отрын бүс нутаг дээр 10 гаран өрхийн 7, 8 мянган мал одоо хүртэл байж байгаа. Эд нар ингээд зусдаг гэж байгаа юм угаасаа. Энэ дээр би сая сайдын энэ яамнаас ирсэн танилцуулга дээр нэг юм 9 отрын бүс нутагт 2 2022-2023 онд 776.1 мянган толгой мал өвөлжиж, хаваржуулж шийдвэрлэснээс 590.8 мянган мал өвөлжлөө гэж байгаа байхгүй юу.

Яахаараа ийм худал тоог та нар ичихгүй сайддаа өгдөг байна. Өнөөдөр ганцхан Хэрлэнбаян-Улаанд гэхэд 493.3 мянган толгой мал 10 аймгийн шүү. Өвөлжөөд байгаа шүү дээ. Тэгэхэд та нар сайддаа ийм худлаа юм хэлээд Байнгын

хороон дээр уншуулаад сууж байдаг. Энэ айлуудаас чинь гараагүй байна одоог хүртэл.

Дээрээс нь энэ сайдын юман дээр ердөө огт дурдагдсангүй. Энэ очсон энэ нэг айлуудаас чинь 26 шүлхий, мянган цэцгийн голомт үүсчхээд байгаа шүү дээ. Тэр талаар яагаад дурдахгүй байгаа юм та нар. Сайддаа мэдээлэл өгөөгүй юм байна шүү дээ та нар.

Тэгэхээр бодит байдал сая сайдын уншиж танилцуулсан та бүхний энэ бидэнд ирүүлсэн 2 тэнгэр газар шиг зөрөөтэй. Тэнд ер нь энэ 270-аад мянган малчин өрхийн хэнийх нь мал тэнд орох ёстой юм бэ? Яг ямар дүрэм журмаар яваад байгаа юм? Энийг би тодорхой болгохыг хүсэж байгаа юм. Та нарын ирүүлсэн материал бол анх ийм зорилгоор байгуулагдаж байгаа юм гэж байгаа юм шиг их гоё тайлбартай материал. Та нар шал худлаа юм явуулж байгаа шүү дээ ичихгүй.

Нэг хэдэн юу ч мэдэхгүй хэдэн юм байгаа. Энийг ингээд нэг аргал.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Отрын бүсийн захиргаа бол хуучин нийгмийн үеэс эхэлж мал тэр үед улсын мэдлийнх байлаа. Ингэж ашиглаж ирсэн. Гэхдээ одоо ч гэсэн нийгэм өөрчлөгдсөн гэсэн мал сүрэг үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна гэсэн үзэл баримтлалын үндсэн дээр отрын бүсийн захиргаа бол бас ажиллаж байгаа гэж хэлж болно. Мал сүргээ хамгаалах. Энийг ялангуяа манай бэлчээрийн МАА-тай харилцан адилгүй хур тунадас цас зуд болдог. Энийг зайлшгүй бас байгалийн гамшиг тохиолдсон үед зохицуулах, нүүлгэх, шилжүүлэх ажил гардаг. Энэ дээр бол отрын бүсийн нутаг бол хамгийн хэрэг болдог. Эндээс хамгийн их талбайтай нь бол Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааных 190 мянган га талбайтай. Өнгөрсөн жил гэхэд 4 зуугаад

мянган мал 10 аймгийн 400 мянган мал тэнд өвөлжсөн гэсэн ийм судалгаа тооцоо гарч байгаа.

Бусад бэлчээр отрын бүсийн захиргааны бэлчээр дээр бол 190 мянган мал нь үлдсэн гэсэн ийм мэдээлэл судалгаа яах аргагүй гараад байгаа гэдгийг бас хэлье.

Тэгэхээр ер нь цаашидаа бол нэг аймгийн нэг сумын нутгаас хэтэрхий их ингээж отрын бүсийн захиргааны бэлчээр газар нутаг гэж авах нь бол бас зүй зохисгүй асуудал юм. Тухайн сумын асуудал тавьж тавьж байгаа. Энэ дээр бол ганц Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улааны тэр харьяалагч сум нь Дэлгэрхаан сум төдийгүй Дорнод аймгийн 124 мянган га талбайтай Чойбалсангийнх хүртэл бас асуудлыг тавьж байгаа. Тэгэхээр энийг бол бас Засгийн газрын Хурал энэ тэрээ оруулж бас багасгах тодорхой хэмжээгээр багасгах арга хэмжээ авах нь зүйтэй гэсэн сайдын хувьд бол бас яамны хувьд. Ялангуяа Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаанд бас газар тариалангийн чиглэлээр тусгай тэжээлийн өв үнэт эмийн ургамал тарих чиглэлээр газрыг нэмэгдүүлье гэсэн. Мөн одоо бусад сумынх нь малчид бол бас бид яг өөрийн сумын харьяа газар гэдэг үнэхээр бага байна. Манай мал сүрэг хүрэлцэхгүй багтаж шингэхгүй байна гэсэн асуудлыг тавьж байгаа. Ийм учраас бас эдгээр томоохон хэмжээний газар нутагтай 100 гаран мянган гатай ийм газрууд дээр бас бид эргэж харах нь зүйтэй гэсэн ийм саналтай бодлоготой байгаа гэдгийг бас хэлье.

Ер нь тэгээд 2 дугаарт энэ бэлчээр нутаг их талхлагдаж, өвс бэлчээрийн доройтолд орсны улмаас жооохон цас ороход л нүүдэл суудал энэ отор нүүдэл их болсон. Энэ нь бол сөрөг тал нь малын өвчнийг нэг аймгаас нөгөө аймаг руу шилжих нэг сумаас сум дамжиж бүүр сум давж, аймаг давж өвчин ихсэхэд бол гол нөлөө үзүүлж байгаа гэж бас үзэж байгаа юм.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн тодруулна. Тэгээд сая бас Идэрбат гишүүн хэллээ. Яамны мэдээлэл бас үнэхээр зөрөөтэй байна гэсэн. Тэгээд тэр ер нь энэ мэдээллийг бас манай сайд өөрөө бас илүү их нягталж энэ дээр орж ирэх ёстой шүү. Тэгээд сайд ч гэсэн энэ дээрээ та тэрийгээ бас нөгөө тайлбарлаад өгнө биз.

Идэрбат гишүүн тодруулъя гэж байна.

Ц.Идэрбат: Энэ Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал сумыг хамарсан 190 хэдэн мянган га ийм нутаг байгаа. Дэлгэрхаан сумын 40 хувь, Цэнхэрмандал сумаас энэ 87 мянган га, Дэлгэрхаан сумаас 100 мянган га гээд ингээд орчихсон. Тэгээд энэ чинь одоо отроор ямар ч ашиглах боломжгүй голын эрэг мэрэг эд нар бүгдийг нь 3 сум байгаа Жаргалтхаан гээд. 3 сумыг хамруулаад. Тэгээд энэний тал дээр энэ 2007 оноос энэ отрын захиргаа байгуулагдаад энэ дүрэм журам гаргаад ер нь яг юу хийсэн нь ямар ч үр дүн байхгүй. Тэнд 2 нөхөр л байгаа. Бусад аймагт ч ер нь ялгаагүй юм шиг байна лээ шүү дээ. Юу хийсэн нь мэдэгдэхгүй. Хэдэн дарга нарын мал байдаг шүү мэдээллүүд ирээд байгаа.

Энэ асуудлыг хөндөхөөр дардаг. Тэгэхээр би Байнгын хорооноос ингээд бүүр нэг ажлын хэсэг гаргаад энэ дээр ажиллаад энэ бусад энэ юунууд руу очиж үзээд мэдээллүүдийг малчдаас аваад тэгээд бодит.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн саналаа хэллээ. Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Асуулт ч адилхан байна даа. Жишээ нь Хэнтий дээр 3 сумынх гэж байгаа. Булган дээр чинь бас 3 сумынх байгаа байх Рашаант, Баяннуур, Дашинчилэн гээд.

Тэгээд энэ ер нь яг зөв юм уу, буруу юм уу? Энэ чинь яах вэ мэдээж байгалийн давагдашгүй хүчин зүйл гээд бэлчээрийн

даац энээ тэрээ гээд л тухайн жилийн гарц юу гэдэг юм ногооны гарцаас авхуулаад ч байдаг юм уу? Ингээд бид нар нүүдэл суудал энээ тэрээ хийгээд энэ Монгол нөхцөлдөө бол байх л байх. Гэхдээ нутаг орон нь өөрөө өөрсдийгөө энийгээ бэлчээрээ хамгаалаад, бэлчээрээ тордоод магадгүй зүгээр одоо ган, зуд болсон үед бол нэгэн дээрээ бол тодорхой хэмжээний аймгууд хоорондоо гэрээгээ хийгээд, малчдаа оруулаад туслаад дэмжээд ингээд явдаг энэ зах зээлийнх нь зарчим руу орохгүй юм уу айн?

Тэгээд социализмын үеийнхээ юман дээр бол байгаад л нэг аймгийн 3, 4 сумынх нь газрыг ингэж авчхаад тэгээд үнэн шүү. Тэр нөгөө дандаа дарга нарын арын хаалганых нь хүн, мал очиж ордог. Тэгээд гардаггүй, зусдаг. Тэр энэ отрын газрын дарга л юмыг хамаг юмыг мэдэж байдаг нэг л эрх мэдэлтэй хүмүүс байдаг. Нууц биш шүү дээ энэ чинь бүгдээрээ тэрний л арын хаалга тэрний л хүмүүс нь л очоод л зусаад л өвөлжөөд л явж байгаа шүү дээ.

Жишээ нь манай аймаг дээр бол энийг дэмжихгүй байгаа. Бодвол бусад нь адилхан л байгаа байлгүй. Үгүй ээ тэгээд энэ чинь бэлчээр чинь адилхан гандаад байгаа шүү дээ. Адилхан л тэр бэлчээрийн даац юмнууд чинь одоо хамгаалалтад бол байж чадахгүй л байгаад байгаа шүү дээ. Цаашидаа тэгээд л ингээд л гайхалтай юм шиг нэг парк шиг л ингээд байгаад байх юм уу? Байгалийн үзэсгэлэнт газар эсвэл юу шиг ингээд бариад байх юм уу эсвэл тэрийгээ тордоод байх юм уу? Ямар ч явцгүй болчхоод байна шүү дээ. Тийм болохоор би энийг одоо цаг үеэ мэдрэхгүй байна. Ер нь зах зээл рүүгээ ороод яг өөр өөрсдийнхөө аймгийнхаа асуудлуудыг шийдээд тэндээ бэлчээрийнхээ даац юмнуудыг зохицуулаад ингээд явах нь зүйтэй л гэж үзээд байгаа юм л даа.

Тэгээд одоо яг дахиад л асуулт асууя. Яг цаг үеэ олсон энэ зүйл маань мөн юм уу? Цаашиаа ингээд аваад явах юм уу? Авч явах нь хэр зохистой байгаад байгаа юм. Хэр баталгаатай байгаад байгаа юм?

Жишээ нь Хэнтий дээр арваад аймгийнхан аймгийн мал орлоо л гэдэг ямар ямар аймгийн малууд орсон, туувар орсон юм. Нөгөөтээгүүр нэг асуудал байгаа шүү. Бид нар өнөөдөр махаа зах зээлд гаргая гэж бодож байгаа бол олон улсын стандартаараа тэр олон улсынх нь хүрч ирээд бид нарын махыг сонирхдог хэмжээнд бид нар энэ малынхаа шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, ёстой. Эмчилгээ бүх юмнуудаа хийх ёстой. Тэгж байж бид нар олон улсын стандартад хүрч байж гаднынхан маань бидний махыг бол авна шүү дээ. Ингээд л нүүгээд л отрын бүс гээд л ингээд л тийшээгээ нааш нь цааш нь хамаагүй нүүлгэж сэлгээгээд л ингээд л яваад байх юм бол бид нарын нөгөө нэг малын эрүүл мэнд, нөгөө гадаад стандарт, нөгөө олон улсын мал эмнэлгийн газрын шаардлага энэ чинь яах билээ?

Тэгэхээр би бол энэ асуулт бас энэ дээр дахиад нэг сонсёё ер нь бол яг цаг үеэ олсон ийм бодитой юм цаашиаа аваад явах ёстой мөн юм уу биш юм уу гэдэг дээр нь хариулт өгөөч.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулъя.

Тэгэхдээ ер нь бол мэдээллүүдээ маш эрт яг өгсний дараагаар та нарт бэлэн л байх ёстой. Сая жишээ нь сайдын гарын үсэгтэй сая мэдээлэл орж ирж байх жишээтэй. Тэгэхээр цаашидаа бас энэ гишүүдийнхээ мэдээллээр хангах тал дээр илүү их анхаарч ажиллаарай гэж хүсье. Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Мал сүрэг хэдийгээр хувийнх ч гэсэн үндэсний баялаг бөгөөд төрийн хамгаалалтад байна гэж Үндсэн хууль дээр заасан болохоор төр зайлшгүй бас гамшиг, ган зудтай үед бол оролцож энэ аймаг дундын отрын бэлчээр ашиглуулах байдлаар ингэж оролцож байгаа юм. Цаашидаа бол байх нь бол мэдээж. Гэхдээ энэ Засгийн газрын 2007 оны 187 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын нийтлэг журмыг шинэчлэн

батлах гэж цаашидаа ингээж санал оруулсан байгаа манай яамнаас. Энэн дээр бол зэргэлдээ аймгуудын мал орохоос биш бүүр аймаг дамжиж орохыг бүүр хориглох ёстой юм. Яг энэ отрын бүсийн бэлчээр дээр бол ажиглахад тэр гарахгүй байгаа малчид бол бүүр аймаг дамжиж орж ирсэн малчид бол гардаггүй юм байна лээ. Тэгээд л тэнд зусчих гээд байдаг. Бөөн хэрүүл маргаан тэнд 2 хүн яг хугацаанд нь гарах гээд л хэрүүл уруул болж байж. Зарим нь зодоон цохион хүртэл болж асуудалд тэр эрүүгийн хэргээр хүртэл явсан асуудал бий.

Өөрөө тэр бас нэлээн бэлчээр ашиглалтын энэ маргаантай болохоор нэлээн хэл амтай ажил л даа. Тэрнээс тэнд нэг эрэгтэй дархтай 2, 3 хүн ажиллаж байгаа асуудал байхгүй.

Хоёрдугаарт зэргэлдээ аймаг бол өөр хэрэг. Аймгаас аймаг дамжиж энэ отрын аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын тэр бэлчээр ашиглаж байгаа нь бол нөгөө өвчнийг бүр хол зөөх, аймаг дамжуулж давуулан зөөх ийм бас үндэслэл болоод байгаа учраас энэ аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын тэр 2007 оны 187 дугаар тогтоолыг бол шинэчлэн батлах хэрэгтэй гэсэн ийм саналтай байгаа юм.

Цаашидаа бол байж таарна. Гэхдээ бол 100 гаран мянган гагаар нэг сумын 50 хувийг нь, 60 хувийг нь хүртэл отрын бүсийн захиргаа гээд захиргааны мэдэлд бэлчээрийг нь авч байгаа байдал бол бас зохисгүй юм гэсэн ийм саналтай байгаа гэдгийг бас хэлье.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүнээс асуусан Идэрбат гишүүний микрофоныг өгье.

Ц.Идэрбат: Тийм Бат-Эрдэнэ гишүүн бол бас яг нэг Булганы асуудлыг бас ярьж байна. Ер нь хаа сайгүй ийм замбараагүй болчихсон юм билээ. Тэгээд ер нь яг Хэнтий аймагт гэхэд энэ 2022-оос 2023 онд Хэнтий, Төв, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай, Ховд, Баянхонгор,

Увс, Хөвсгөл, Улаанбаатар, Баянзүрх, Багануур, Багахангай, Налайх. Одоо тэнд Ховд аймгийн Мянгад, Баянхонгор, Төв аймаг, Багануурын баахан өрхүүд ингээд байж байна гэж байгаа юм.

Одоо малын гоц халдварт өвчний голомт үүсчихсэн. Нэг ч удаа отрын бүс нутгаас ариутгал халдваргүйтгэлийн ажил хийж байгаагүй. Одоо намайг 10 хоногийн өмнө очиход тосгоны дарга нь байгаа 3 сая төгрөгөө мялзанд зориулаад дуусчихсан. Төрийн албан хаагчид нь нөгөө баахан сэг зэм хог шороог нь цэвэрлэх гэж бөөн хар ажил байж байгаа. Ядарчихсан байж байгаа. Тэгээд л тийшээ нэг хэдэн эрх дархтай хүмүүс нэг баахан мал оруулаад л араас нь хүүе хаая ч гэдэггүй. Нэг ийм л дүр зурагтай байгаа шүү гэдгийг хэлье.

Б.Саранчимэг: Мөнхцэцэг гишүүн асуултаа асууя.

Г.Мөнхцэцэг: Энэ отрын бүс дамжсан энэ хэрүүл маргаан ер нь тэгээд л жилээс жилд ер нь нэлээн ужгирах маягтай даамжрах маягтай л болоод байна л даа. Тэгээд сая бас гишүүдийн хэлж байгаа тэр ариутгал хамгаалалтын ажлууд нь хийгдэхгүй байна. Ялангуяа тэр малын сэг зэмийг арилгах тал дээр ядахдаа төсөв юмнууд тавигддаггүй учраас үндсэндээ хэдхэн хүний нуруун дээр яваад ингээд энийгээ дийлэхгүй байна гээд ийм хүндрэлүүд бас байна.

Тэгээд ер нь бол бид нар энэ Отрын бүс гэж байх ёстой юм уу үгүй юм уу? Малчид бас тэр болгон тийм их таатай бас хүлээж авдаггүй. Яах вэ отроор явж байгаа малчдын хувьд мэдээж бас энэ хэрэгтэй. Гэхдээ тэр тухайн отрыг хүлээж авч байгаа тэр бүс нутгийн малчдын ард иргэдийн хувьд бол энэ бас их хүндрэл байгаад байдаг аа. Тухайлах юм бол зүгээр энэ Хэрлэнбаян-Улаан гэхэд л ийм хэмжээний га талбайгаа отрын бүсэд өгчихсөн байдаг. Ялангуяа манай Говьсүмбэр аймаг гэхэд Малхын тал гэхэд энэ өөрөө ямар нутаг дэвсгэрийн хэмжээтэй байлаа гэтэл эндээс чинь 73.1

мянган га талбай нь гэхэд отрын бүсэд байж байдаг. Малых тэгээд ирэхээр ингээд эндээс болоод ингээд газар нутгийн маргаан ч үүсэж байна.

Дээрээс нь зөвхөн энэ 2 аймгийн нутаг дэвсгэрт гэхэд өнөөдөр ингээд л 10 аймгийн малчид ирээд ингээд оторлоод явж байх жишээний.

Тэгэхээр ер нь яаж бид нар энэ отрын бүсээ дахиад эргээд ингээд тордох юм? Ер нь бол бид нар отрын бүс хамгийн үржил шимтэй тэнд бас хаваржилт өвөлжилт тодорхой хэмжээгээр бас байх боломжтой гээд аль хэдийн тэр төлөөлж өгсөн тэр социализмын үед төлөөлж байсан тэр төлөвлөлтөөс чинь өнөөдөр газар нутгийн онцлог ч өөр болчихсон байна. Байгаль орчин ч өөрөө бас өөр болчихсон байж байгаа. Тэгэхээр дахиад төлөвлөлт хийхээсээ илүүгээр энэ газар нутгуудаа яаж тордох юм цаашаа бид нар ямаршуу арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх юм гэдэг тал дээр илүү яам бодлого барьж ажиллавал одоо бас зүйтэй юм болов уу гэж бас ингэж харагдаад байдаг. Тэгээд ер нь бол малчид ярьж байгаа шүү дээ. Бид яах вэ? хаашаа хамгаалалт юмнуудаа хийгээд энэ бэлчээрээ бас хамгаалдаг больё. Өөрсдөө бас тариа будаа тарьдаг больё. Ингэж ер нь малчдыг дэмжих отрын бүсийг нэмэхээсээ илүүгээр тухайн тэр суурьшмал байгаа малчдаа дэмжих ийм бодлогыг бас төр анхаарч ажиллавал бидэнд бас хийхгүй ажил бас алга байна гээд ингээд яриад байдаг.

Тэгэхээр энэ одоо яг отрын бүсээ нэмнэ гэхээсээ илүүгээр буцаад эргээд энэ отруудад байгаа бүсчилсэн энэ нутгаа яаж бас ингэж тордох тал дээр ер нь яам ер нь ямаршуу бодлого хэрэгжүүлмээр байгаа юм. Яаж хэрэгжүүлээд байгаа юм гэдэг дээр зүгээр асуулт байна. Тэгэхдээ ер нь зовлон байгааг ойлгож байгаа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайдын микрофоныг өгье.

Х.Болорчулуун: Манай улсад сүүлийн үед гарч байгаагүй өвчнүүд их гарч олиширлоо. Энэ бол хонины мялзан өвчин гэхэд 2016 он хүртэл ер нь байхгүй байсан. Мялзан өвчин энд тэндгүй аймгуудад тархлаа. Шүлхий өвчин бүх л аймагт тархлаа. 21 аймгаас 20 аймагт нь тархсан. Тэгэхээр энэ юу хэлж байна гэхээр бас бэлчээр нутгийн доройтолтой холбоотойгоор нүүдэл суудалд хийх бүсээс бүс, аймгаас аймаг дамжуулж бүүр давуулж ингэж отор нүүдэл хийх мал сүргээ зөөхтэй холбоотой энэ өвчин даамжирсан гэж үзэж байгаа юм.

Тийм учраас ер нь цаашидаа бол энэ зөвхөн зэргэлдээ аймгийн мал тухайн отрын бүсийн бэлчээр рүү ордог. Ийм байхаар бүүр хууль журамд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж бодож байна. Тэрнээс Ховдоос очоод Хэнтийд нутаглах нь утгагүй байхгүй юу. Энэ чинь тэр тэр газрын Ховдын өндөр уултай газрын мал, тэрний хөрс шороо ургамал, Хэнтий Дорнодын хөрс шороо ургамалд дасахгүйгээс болж өвчин хүрэх өвчин тараах ийм байдал үүсгэж байна гэсэн ийм дүгнэлтэд бас хүрээд байна.

Хоёрдугаарт энэ 100 гаран мянган гатай энэ аймаг сумдын отрын бүсийн захиргааны газар нутгийг багасгах нь зайлиггүй шаардлагатай. Энийг бол яам бодлогоор оруулна. Засгийн газрын хурлаар оруулна.

Цаашидаа энэ газрын хэмжээ бас багасгаж тохирсон хэмжээнд нь байлгахаар бас хуулийн зохицуулалтыг хууль журмын зохицуулалтыг хийнэ гэсэн ийм бодлоготой ажиллаж байна гэдгийг бас хэлье. Тэрнээс биш бүүр отрын бүсийн захиргаа нутаг бэлчээр байхгүй гэж болохгүй ээ. Энэ мал төрийн хамгаалалтад байдаг ган болох, зуд болоход зайлиггүй бас ийм нутаг руу шилжин байрлаж орох ийм зүй ёсны шаардлага гардаг гэдгийг бас ийм учраас мал сүрэг төрийн хамгаалалтад байна гэсэн үзэл баримтлалын үндсэн дээр бас аймаг дундын отрын бүс нутгийн бэлчээр

ашиглалтыг бас явуулж байгаа шүү гэдгийг бас хэлье.

Баярлалаа.

Б.Саранчимэг: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Санал хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Бат-Эрдэнэ гишүүнээр тасаллаа.

Идэрбат гишүүн саналаа хэлье.

Ц.Идэрбат: Отрын бүс нутгийн асуудал ерөнхийдөө ямархуу байдалтай байгаа вэ гэдгийг нь та хэд бэлхнээ харж байна. Сайд та өөрөө өвөл яг очоод газар дээр нь бас ажилласан, Шадар сайд та бүхэн ямархуу хүнд нөхцөлд байгаа вэ гэдгийг хэдүүлээ харсан учраас энэ дээр ер нь нэг зарчмын 2, 3 том өөрчлөлт хийх гэж үзвэл яасан юм бэ?

Нэгдүгээрт Бат-Эрдэнэ гишүүний хэлж байгаа бидний энэ байгуулагдаж байсан отор дундын бүс нутаг, аймаг дундын бүс нутаг байгуулагдаж байх үед тэр нийгэм солигдоод 30 жил болчихсон. Тэр үеийн цаг уурын нөхцөл байдал, байгалийн нөхцөл байдал бүүр шал өөр болчихсон.

Тэгээд одоо энд отрын бүс нутаг байлаа байлаа гээд ингээд үзэхэд энэ 250 мянган малчин өрхийн хэнийх нь орох юм. Энэ 70 сая малынхаа хэнийг нь оруулах юм. Хамгийн том гэж байгаа. Хэрлэн Баян-Улаанд өнөөдөр 1 400 гаран мянга арай чамай л багтаж байна шүү дээ. Бүтэн нэг сумын малын 4-ний 1 л орж байна шүү дээ. Тэгэхээр ер нь цаг хүндэрлээ гэхэд ингээд нэг отрын бүс нутагт аваачаад байршуулчих юм шиг нэг ийм горьдлого хэлж байх ер шаардлага ер нь байгаа юм уу? Тийм учраас энэ отрын бүс нутаг гэж үзэж байгаа энэний маань ургамлын бүтэц эд нар шал өөр болчихсон юм байна лээ. Тэнд насаараа байсан хүмүүс хэлж байна шүү дээ. Дөрөө шүргэсэн сайхан үе байсан. Одоо бол хамар хатгахад хэцүү болж эхэлж байна шүү гэж.

Тийм учраас ер нь энэ отрын бүс нутаг гэдэг энэ зүйл байх эсэхийг ер нь бас энэ ажлын хэсэг дээр Байнгын хорооноос ажлын хэсэг гарч энэ газар дээр нь очиж ажиллаж бас нэг тодорхой дүгнэлттэй бол яасан юм бэ гэсэн нэг ийм юм байгаа юм.

Хоёрдугаарт ер нь бид цаашдаа ингээд зуд болох юм бол сумын нөөц өгөх юм шиг, аймгийн нөөц өгөх юм шиг. Тэгээд яг сумын нөөцөө задлахаар 2 мянган боодол өвсөөс 3, 3 боодол өвс л портёр дээр тавиад явуулдаг шүү дээ. Бүүр нэг ийм юмнаасаа болиод. Харин тэр бэлчээрээ хамгаалах бэлчээртээ ургамал тарих, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Согоот бригадынхан 150 га-д малчин өрх ногоон тэжээл тариад нэг айл 800-аас мянган боодол ногоон тэжээл авч байна гэж байгаа шүү дээ. Цаг уурын хувьд таатай байж магадгүй.

Тэгэхээр ийм бололцоонуудыг нь л нээж өгөх юм бодож үзэхээс биш энэ отрын бүс нутаг руу оруулах тусламж өвс өгөх юм шиг ийм зүйлүүдээ ер нь болиод явал яасан юм бэ л гэсэн ийм л бодолтой байна.

Тэгээд миний санал бол ажлын хэсэг гаргая. Тэгээд ойрын хугацаанд энэ 9 газрыг бүсчлээд нэг ингээд яваад үзье, уулзъя, малчидтай уулзъя. Ингэснийхээ ар дээр Байнгын хороонд ажлаа танилцуулъя гэсэн ийм л саналтай байна.

Б.Саранчимэг: Ер нь бол энэ отрын бүс гээд ирэхээр л яах аргагүй энэ бэлчээртэй холбоотой. Тэгэхээр энэ бэлчээрийн хууль эрх зүйн орчныг 10 жилийн өмнө малчидтай уулзаад явж байхад юун хууль эрх зүйн орчин бэ гэдэг байсан бол ерөөсөө энэ хууль эрх зүйн орчинтой болохгүй бол болохгүй болсон байна гэдэгтэй санал нийлж байгаа. Тэгэхээр зүүн бүсийн хэлэлцүүлгийг манай Идэрбат гишүүн бас удирдаад очиж олон малчидтай уулзсан. Миний бие говийн бүсийн малчидтай яг тэр газрын албаны чухал хүмүүстэй яг хариуцаж байгаа хүмүүстэй очиж уулзаад явахад үнэхээр

энэ бэлчээрийн хууль эрх зүйн орчныг сайжруулахгүй болохгүй ээ. Мал өөрөө бас хувийн өмч, газар төрийн өмч. Энэ 2-ын хууль эрх зүйн зохицолгоог сайжруулж хууль эрх зүйтэй болохгүй бол үнэхээр энэ бэлчээр чинь талхлагдаад дууслаа.

Дараагийн 10 жил өнөөдөр бид нар бэлчээртээ байх уу үгүй юү гэдэг ийм бас үндэсний том асуудал болчихсон байгаа энэ үед цаг үед бид нар бас чухал асуудлыг хэлэлцэж байна.

Тэгэхээр өнөөдрийнхөө энэ саналын дагуу бас бид нар протоколоор үүрэг өгөөд бас ажлын хэсэг гаргаад явъя.

Тэгэхээр Идэрбат гишүүн өөрөө энийг бас ахлаад явна биз. дараагийн санал дээрээ бас би өөрөө саналаа хэлээд явчихъя.

Бат-Эрдэнэ гишүүн бас үгээ хэлье.

Ж.Бат-Эрдэнэ: Болорчулуун сайдаа энийгээ ерөөсөө татан буулгаад энэ аймаг аймагт нь өгвөл яасан юм бэ? Энэ одоо жишээ нь Баяннуурынх дээр 22 мянган толгой мал гэж байна. Мянган малтай айл бол 22 өрх л орох юм байна шүү дээ. Ямар өрх нь орох юм. Арын хаалгатай нь орох юм уу эсвэл мөнгө их төлсөн нь юм уу, таньдаг нь ордог юм уу дарга нь ордог юм уу? Үгүй ээ энэ чинь ийм замбараагүй юм байж болохгүй шүү дээ. Аргалантынх гэхэд чинь 30 мянган мал, дахиад л 30 өрх. Ямар өрх нь орох юм? Бүүр л Улаанбаатараас хүртэл оччихсон байж байна. Баянхонгор гэсэн үү? Сая юу гэсэн, Хөвсгөл, Ховд үгүй ээ, тэгээд тэр тэд чинь яасан юм? Тэр хүртэл ингээд малаа туугаад мөнгөтэй төгрөгтэй хүмүүс нь ордог юм уу тэгээд ийм замбараагүй юм гэж байна гэж юу байсан юм бэ?

Хоёрдугаарт бид нар чинь юу билээ нөгөө эрчимжсэн мал аж ахуй руугаа орох түрүүн хэллээ шүү дээ. Тэр тэжээл тариалдаг болох хагас эрчимжсэн рүүгээ орох хүссэн хүсээгүй энэ байгаль чинь гандаад дууслаа. Тэгэхээр малынхаа ам

руу хамар хатгах өвсгүй болж байна шүү дээ хаа сайгүй.

Тэгэхээр энэ нэг хэдхэн газар руу шаваад байх юм уу хэдүүлээ ийм ойлголтыг байлгаад байх юм уу? Нөгөө шавдаг газар чинь ч шавахааргүй хэмжээнд болчихлоо шүү дээ. Тэгээд цаашаа байлгана гээд байхаар яах юм зүгээр сайхан нэртэй нэг хэдэн хүмүүсийг тэжээгээд л байж байна гэсэн үг шүү дээ. Аймаг орон нутагт нь өг л дөө. Аймаг орон нутаг нь энэ дээр өөрсдөө менежмент хийгээд яваг л дээ. Хажуу талынхаа таны хэлж байгаагаар бол тэр хажуу талынхаа хөрш зэргэлдээ аймгийнхныгаа оруулья гэж байгаа бол тэд нар нь аймаг нь өөрөө менежмент хийгээд Булганыхан бол цаашаа Өвөрхангайнхан. Тэртээ тэргүй Өвөрхангайнхан манайх руу тэр чигээрээ нүүгээд л ирж байгаа шүү дээ. Дундговийн хүн тэр чигээрээ нүүгээд л бас ирдэг л байсан шүү дээ. Тэгэхээр аймаг, аймагт нь өгөөд, менежментийг нь хийгээд, хооронд нь зохицуулалтыг нь хийгээд, ингээд л өгөөд, бусдыг нь бол татан буулгаад аймагт нь өөрсдөө засаг захиргаа нь бол мэддэг л болгочихмоор байх юм.

Хоёрдугаарт бид нар ингээд цааш цаашаагаа ингээд ер нь байгаль орчин маань ингээд гандаад өвс ургамалд нь ч байхгүй болж байгаа больж байна. Хүссэн хүсээгүй бид нар нөгөө ногоо тэжээл рүүгээ орж байгаа шүү дээ. Захын малчин энэ өвс ургамал тариалах малын тэжээл тариалах малын тэжээл бэлдэх эд нар гэдэг рүү орчхоод байна шүү дээ. Аль хэдийн орчихсон. Тэгээд ийм зэрлэг хөдөө аж ахуйтай, зэрлэг мал аж ахуйтай бид нар хэдий хүртэл явах юм? Өнөөдөр, хавар ингээд гунхчихсан ийм талаар дүүрэн л гунхчихсан л мал явж байгаа шүү дээ. Хаана очоод унах нь мэдэгдэхгүй, унасныг нь арай гэж өргөөд л ингээд л хавардаа оруулж байдаг ийм аж ахуй гэж юу байх вэ дээ.

Хэдүүлээ тэгээд нэг газраас нөгөө рүү нь нүүнэ гээд ингээд явж байдаг. Мал

аж ахуйнхаа энэ мэргэжлийн хүмүүс эндээс ичих хэрэгтэй шүү дээ. Та нар ийм юм яриад сууж байх юм. Шал ондоо өндөр түвшиний мал аж ахуй ярьж байх ёстой байтал нүүлгэн шилжүүлэлтийн асуудлуудыг яриад сууж байна гэдэгт нь үнэндээ бол мал аж ахуй талаасаа бол ичих хэрэгтэй, яам. Энэ чинь аль хэдийн зэрлэг аж ахуй, зэрлэг мал аж ахуйгаасаа бид нар салчих хэмжээнд очиж байна шүү дээ. Тэгээд мал аж ахуйн орон энэ тэр гээд бид нар өөрсдийгөө цээжээ дэлдээд л байдаг. Яг гаднынхнаа харахад бол манай малыг харж үзэж бид нараас мах худалдаж авъя гэдэг улс орон байхгүй цаана чинь.

Та нар өөрсдөө тэрийг мэдэж байгаа шүү дээ. Тэр хэмжээнд бид нар хүрэх ёстой гэдэг зорилго тавьснаа мэдэж байгаа шүү дээ. Малынхаа өвчин нь ямар байгаа билээ, мал аж ахуй нь ямар байгаа билээ. Цаад улс орнууд чинь бид нарыг тоохгүй байгаа шүү дээ өнөөдөр. Урд хөрш чинь ч тоохгүй хойд хөрш чинь ч тоохгүй. Эднийх бол ерөөсөө тэгсхийгээд ингээд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль бид нар хийгээд хамтдаа сууж байсан улс орныхон чинь бол тэр мэргэжлийн байгууллага нь бол хэлж байсан шүү дээ. Үгүй ээ танайх чинь яг энэ түвшинд ингээд зэрлэг мал аж ахуйтай байх, бэлчээрийн мал аж ахуйтай байхад бид нар бол гаднынхан бүр стандарт нь өндөр явчихсан болохоор танай мал экспортод гарах нь бол үнэхээр бас дутагдалтай шүү гэдгийг хэлж байсан шүү дээ. Хэдүүлээ сонсож л байсан, үзэж л байсан.

Тэгэхээр шал ондоо өнцгөөс нь харж энэ мал аж ахуйгаа тэр тусмаа энэ бэлчээртэй холбоотой асуудал.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд саналаа хэлье.

Х.Болорчулуун: Бид аймаг дундын отрын бэлчээрийг бол гэнэт байхгүй болгочих нь бол бас зохисгүй ээ. Гэхдээ би түрүүний хэлсэн аймгаас аймаг давуулж одоо отор нүүдэл хийдэггүй. Зөвхөн бүс

нутгийнхаа хэмжээнд хөрш зэргэлдээ аймаг руугаа энэ бэлчээрийг нь ашиглаж отрын бүсэд ордог. Ийм байдлыг бол хууль журмын дагуу шийдэх нь бас зүйтэй гэж бодож байна.

Хоёрдугаарт энэ их хэмжээний га талбайтай Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан, Дорнод аймгийн Чойбалсан, Ховдын Зуу, Баяннуурын отрын бүсийн газар нутгийг ер нь багасгах нь зүйтэй гэсэн ийм бодолтой байгаа юм. Байнгын хорооноос ажлын хэсэг гарахаар түрүүнд Байнгын хороон дарга хэллээ.

Идэрбат гишүүн бол тэгээд л хамгийн их мал ордог гаднаас ордог нутаг бүхий тойргийн гишүүн. Тэгэхээр бас өөр аймгуудтай юуны ашиг сонирхлын зөрчил үүсгэх янз бүрийн юм байх уу гэдэг чинь асуудал гарна шүү. Тэгэхээр мэдэж түрүүний Бат-Эрдэнэ гишүүний хэлдгээр аймаг аймагт нь өгчихвөл аль болохоор аймгууд оруулахгүй л гэнэ. Ямар ч ган зуд болсон зуд болсон манайх оруулахгүй л гэнэ. Тэгэхээр энд яалт ч үгүй мал сүрэг төрийн хамгаалалтад байна гэсэн үндсэн дээр төр, яам бас зохицуулж байгаа юм гэдгийг бас хэлье ээ. Тэрнээс биш бүр байхгүй болгох ч юм уу зөвхөн аймагт нь өгнө гэсэн асуудал одоогоор байж болохгүй ээ.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн бол ашиг сонирхлын зөрчилгүй гэж харж байгаа. Тэгээд ямар ч байсан бас ийм чухал асуудлаа хөндөж байгаа юм чинь энэ дээр бид нар бас ажлын хэсэг гаргаад Идэрбат гишүүн бас санал гаргасан учраас энэ ажлын хэсгээ ахлаад явна.

Тэгээд энэ ажлын хэсгийн тал дээр бас та бүхэнд танилцуулна. Тэгэхээр бид нар өөрөө санал гаргасан та ажлын хэсэгт орж болно бас. Тэгэхээр ер нь бол бид нар энэ бэлчээрийнхээ асуудлыг үнэхээр шийдэхгүй болохгүй болчихсон. Тэгэхээр энэ говийн аймаг ч гэсэндээ яг үнэхээр тэр бэлчээрээ шилжинэ үү гэхэд очоод үнэхээр ямар байдалд орчихсон байгаа билээ. Энийг бас хэдүүлээ бодлогоор хийхгүй бол нэг аймагт

оруулахгүй гэсэн энэ бас хатуу саналыг ер нь бид нар бас яг нэг хууль эрх зүйн орчноор их зөв зохицуулж өгөхгүй бол бас бүх л малчдаа бодсон бодлогыг гаргахгүй бол болохгүй гэж харж байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсэг илүү их энэ дээр анхаарч ямар нэгэн ашиг сонирхлын зөрчилгүйгээр ажиллана гэдэгт бас итгэж байна.

Тэгэхээр мэдээлэл сонссонтой холбогдуулан энэ аймаг дундын отрын бүс нутгийн асуудлыг судлан үзэж Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулъя. Тэгэхээр өөрсдөөс нь бүгд санал авсан байгаа. Тэгэхээр энэ ажлын хэсгийн ахлагчаар Идэрбат гишүүнийг томилоод Ж.Бат-Эрдэнэ гишүүн ороод, Мөнхцэцэг гишүүн миний бие Батжаргал гишүүн ингээд ороод энэ ажлын хэсгийг өшөө бас тэгвэл нээлттэй бас орхиё тэгэх үү? Нээлттэй орхиод энэ дээр бас энэ 5 гишүүн саналаа ирүүлчихсэн байна.

Тэгэхээр яг ажлын хэсэг байгуулахыгаа эцэслэхдээ бас бусад гишүүдээс бас асуугаадхаарай. Тэгэхээр ийм ажлын хэсэг байгуулъя гэсэн саналаар санал хураалт явуулъя.

Санал хураалт. 60 хувиар ажлын хэсэг байгуулахыг зөвшөөрлөө. Тэгэхээр ажлын хэсэгт бас яг газар дээр нь очиж зөв шийдвэр гаргах яг энэ гишүүдийнхээ оролцоог илүү хангаж ингэж ажиллахыг хүсэж байна.

16.53 цагт

Дараагийнхаа асуудалд оръё.

Өнөөдрийн ирсэн ажлын хэсгийнхэнд баярлалаа.

Дараагийн асуудал.

Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн

үйлдвэрийн сайдын мэдээлэл сонсох байгаа.

Түрүүний яамны ажлын хэсэг яг хэвээрээ байгаа учраас дахиж хэлээд яах вэ. Тэгэхээр Болорчулуун сайдыг мэдээллээ танилцуулахыг хүсэж байна.

Х.Болорчулуун: Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Ерөнхийлөгчөөс хүнсний сүлжээний бүх үе шатад аюулгүй байдлыг хангах гол нэрийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах цаашид хүнс экспортлогч орон болох зорилтыг дэвшүүлсэн.

Дээрх зорилтын хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлаас хүнсний хангамж аюулгүй байдлыг нь хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг баталж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын эрх зүйн орчин удирдан зохион байгуулалт, бодлого, үйл ажиллагааны цогц шинэчлэлийг хийхээр шийдвэрлэсэн.

Тогтоолыг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 5 чиглэлийн хүрээнд 41 үйл ажиллагаа 114 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд 2023 оны хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээгээр 8 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 28 арга хэмжээ хэрэгжих шатанд буюу 70 хувийн биелэлттэй, 68 арга хэмжээ хэрэгжилт хангалтгүй буюу 30 хувийн биелэлттэй 7 арга хэмжээ хэрэгжээгүй буюу 0 хувийн биелэлттэй 3 арга хэмжээ хэрэгжилт тооцох хугацаа болоогүй гэж тус тус үнэлэгдсэн.

Та бүхэнд тогтоолын хэрэгжилтийн талаар товч танилцуулъя.

Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгохоор шинээр боловсруулах 4 хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах 4 хуулийн төсөл, 12 журам, заавар болон аргачлалыг боловсруулан батлуулахаар тусгагдсан

бөгөөд энэ хүрээнд нэг хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж Мал аж ахуйн салбарын харилцааг зохицуулж байгаа. Мал амьтны эрүүл мэнд тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын генетик нөөцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтан, ургамлын тэдгээрийн гаралт, түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг боловсруулан 2023 оны 5 сарын 9-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон.

Мөн гол нэрийн 19 хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ бүрэн хангах зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зээлийг олгохоор 2023 оны төсөвт 127.5 тэрбум төгрөг тусгагдаж арилжааны банкны эх үүсвэрээс санхүүжүүлэн Засгийн газраас хариуцан төлөх хүү хэмжээг 13 хувь байхаар шийдвэрлэсэн.

Зээлийн санхүүжилтийн ерөнхий гэрээг 2023 оны 3 сарын 30-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам арилжааны 10 банкнуудтай зээлийн хүүгийн хөнгөлөлтийн санхүүжилтийн ерөнхий гэрээг Сангийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монголбанктай хамтран байгуулсан юм. Ерөнхий гэрээний дагуу хүнс, хөдөө аж ахуй үйлдвэр эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж хоршоод эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зээлийг 5-аас 6 хувийн хүүтэйгээр 3-аас 5 жилийн хугацаатай мал аж ахуйн үйлдвэрлэлд 132.3 тэрбум газар тариалангийн үйлдвэрлэл 342.6 тэрбум, хүнсний боловсруулах үйлдвэрлэл үйлдвэрлэлд 507 тэрбум төгрөгийн нийт 982 тэрбум төгрөгийн зээлийн банкны эх үүсвэрийг зээлийг банкны эх үүсвэрээс олгож байгаа болно.

2023 оны 5 дугаар сарын байдлаар Хүнс, хөдөө аж ахуй аж ахуйн үйлдвэрлэл дэмжих зээлд нийт 892 үйлдвэр эрхлэгчид 106.8 тэрбум төгрөгийн зээлийг олголоо. Зээл олголтыг харахад газар тариалангийн үйлдвэрлэлийн чиглэлээр 66 тэрбум төгрөгийг хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн чиглэлээр 38.6 тэрбум төгрөгийг, Мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр 2 тэрбум төгрөгийг тус тус олгоод байна. 2.19 тэрбум. Нийт зээлийн 76 хувийг Хаан банкаар, 14.9 хувийг Хас банкаар, 4.3 хувийг Голомт банкаар олгосон.

Цаашид зээл олголтыг эрчимжүүлэн шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. Мөн Улсын Их Хурлын 2022 оны хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг нийт 30 гаруй байгууллага хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан ч эдгээр байгууллагын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Асуултад хариульа аа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайдад баярлалаа. Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Идэрбат гишүүнээр асуултаа тасалъя.

Бат-Эрдэнэ гишүүн асуултаа асууя.

Ж.Бат-Эрдэнэ: Энэ уг нь маш хэрэгцээтэй чухал тогтоол гараад ингээд явж байгаа. Ер нь бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хүнсний хувьсгал шүү дээ. Тэгээд бид энүүгээрээ бол 19 нэр төрлийн бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг бол бүрэн хангая гэж байгаа. Дотоодын үйлдвэрлэлээ хөгжүүлье тэр тусмаа ХАА-н үйлдвэрлэлийг нэлээн сайжруулъя гэж

байгаа шүү дээ. Тэгэхээр дахиад л нөгөө МАА-тай холбоотой асуудал нөгөө бэлчээрийн МАА-гаа бас тодорхой хэмжээнд сайжруулах тэгээд нөгөө үйлдвэрлэлийг жосоохон нэмэгдүүлье гэж байгаа шүү дээ. Тэр дотроо нөгөө тэжээлийн үйлдвэр дээр ер нь ямаршуу ахиц гарч байгаа вэ? Тэжээлийн үйлдвэрлэл тэгээд энэ чинь өөрөө бас нөгөө газар тариалантай холбоотой асуудал болно. Газар олголттой нь холбоотой газарт ААН-үүд байх хэрэгтэй болж байгаа. Тэгээд зохион байгуулалтаар уг нь бид нар ярьсан шүү дээ. Зохион байгуулалтаар тухайн аймаг орон нутгийн засаг захиргаатай ярьж байгаад бодлогоор ААН-үүдийг гаргаж ирээд өөрийн гэсэн газартай өөрийн гэсэн бололцоотой ийм ААН-үүдийг гаргаж ирж байгаад тухайн бүс нутагт тэжээлийн үйлдвэрлэлүүдийг нь барья гээд нэг ийм зүйл гаргасан шүү дээ. Тэгээд энэний чинь цаад талд нөгөө нэг махны үйлдвэртэй холбоотой асуудал, сүүний үйлдвэртэй холбоотой асуудлууд гарч ирж байгаа юм.

Тэгэхээр бодлогоор ийм зүйлүүдийг л хиймээр санагдаад байгаа юм. Энийг хэр их хийж байгаа юм бэ? Тэгэхгүй болохоор зүгээр дунд нь ингээд хаячих юм бол хэн би чадна гэдэг нь гараа өргөж явсаар байгаад л зарим нэг нь авч чадна зарим нэг нь авч чадахгүй ингээд л энэ үр дүнгүй болчих гээд байна л гэж хараад байгаа байхгүй юу даа. Тэгэхээр яг үйлдвэрлэлийн хүрээнд тэжээл үйлдвэртэй холбоотой бол жишээ нь Булган байж байна. Наашаагаа Төв аймаг байж байна. Сэлэнгэ байж байна. Яг бүс нутаг чинь л ерөөсөө энэ 3 аймгийн хүрээнд байж байгаа шүү дээ.

Хоёрдугаарт мал аж ахуйн талаар хэд хэдэн ААН-үүд гарч ирээд байх шиг байна. Махны үйлдвэрлэлтэй холбоотой асуудлууд. Дээрээс нь сүүтэй холбоотой асуудлууд. Сүүгээ бол бид нар онцгой анхааръя гэж ярьсан шүү дээ. Хэдэн аж ахуй сүүний хэдэн аж ахуйнууд гарч ирж байгаа. Улаанбаатар хотоо хэр хангах юм хэдэн ААН-үүд орж ирж байна, хэдэн

ААН-үүд нь зээл юмнуудаа авч чадав гээд яах вэ зээлээ давсан тоо дун гараад байна. Тэгээд энэний чинь цаад талд зүгээр өнөөдөр дөнгөн данган ажиллаж байгааг нь дээш нь татаад байгаа юм уу эсвэл сайн ажиллаж байгааг нь өшөө боломж бололцоогоор нь нэмэгдүүлээд байгаа юм уу. Эсвэл ерөөсөө хүрээгээ нэмээд үйлдвэрлэлээ нэмье гэж байгаа бол дахиад ААН-үүд хийх хэрэгтэй. Дахиад шинээр ААН байгуулна гэхээр урьд нь түүх байхгүй гээд нөгөө банкнууд чинь халгаахгүй байгаад байгаа шүү дээ. Барьцаа хөрөнгө байхгүй гэж нэг асуудал яригдаж байгаа эсвэл бизнес хийсэн түүх байхгүй гэдгээрээ л уначихаар бид нар чинь энэ хүрээгээ л нэмчхэж чадахгүй болчихоод байгаа байхгүй юу даа. Одоо байгаа ААН-үүд чинь яах вэ зүгээр хүчин чадлаа нэмэгдүүлж яваа байгаа байх. Гэхдээ ААН-үүдийнхээ тоог нэмж байж хүрээ нь нэмэгдэж байж энэ үйлдвэрлэл чинь өшөө цаашаа явах ёстой. Энэ талынх нь чиглэлүүд нь хэр болж байгаа юм? Тэгээд банкнуудтай холбоотой асуудлууд миний түрүүний хэлсэн ААН-үүд дээр бол нэлээн бухимдал бас дахиад л гарч байна. Нөгөө нэг 3 хувийн хүүтэй 10 их наядын зээл гэдэг дээр чинь бол нэлээн том асуудлууд бий болсон шүү дээ. Яах вэ тэр бол ковидын үед бол ААН-үүдийг эрчимжүүлээд чадварыг нь дамнууруулахгүй хэмжээнд авч явъя гэдгээр байсан байх. Одоо энэ бол шинээр ААН-үүд дээр нэлээн анхаарал хандуулах ёстой шүү дээ.

Тэгэхээр банкнууд дээрээс ер нь хэр их боломж бололцоотойгоор олгож байгаа юмб Шинэ ААН-үүд хэр их орж ирж байна гэсэн нэг ийм асуултуудад хариулт өгөөч. Баярлалаа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Монгол Улсын нийт аймаг сумдын бэлчээрийн 50-аас 70 хувь нь бас ургамал бэлчээрийн доройтолд орсон гэсэн ерөнхий судалгаа гараад байгаа. Ийм болохоор цаашидаа бол мэдээж сая өөрийн чинь хэлдгээр дандаа

бэлчээрийн МАА-г шүтэн амьдрах ажиллах нь бол үнэхээр хомс эрсдэлтэй болж байгааг харуулж байгаа юм.

Тийм учраас бид нар бол тэжээлийн үйлдвэрлэлийг бүх талаар дэмжих сум фермерүүд хажуудаа тэжээлийн үйлдвэрт явуулах, тэжээл тариалах, ногоон тэжээл тарих ажил зайлиггүй шаардлага өнгөрсөн жилийн энэ хүйтрэлт ган зудаас ч гэсэн харагдаж байна. Тэгэхээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол тэжээлийн ургамлын үр, овъёос болон улаан буудайн үрийг 20-оос 30 хувийн урьдчилгаа төлбөртэйгөөр олгоё гэсэн ийм шийдийг гаргаад ажиллаж байна. Мөн сумдаас судалгаа аваад ямар сумд хажуудаа тэжээлийн ургамал тариалах судалгааг аваад байна. Ер нь нэг сум гэхэд 100 га-гаас доошгүй тэжээлийн ургамал тариалж байж бас нэг ийм цас зуд хүндэрсэн үед бас өвлийг өнтэй давах нөхцөл боломж бүрдэх юм. Мөн одоо Засгийн газарт бас 5 тэрбум орчим төгрөгийг бас энэ тэжээл үйлдвэрт эрхлэх тэжээл тариалахад бас манай хөдөө аж ахуйг дэмжих сан дээр байгаа Мал хамгаалах сан дээр байгаа 4.7 тэрбум төгрөгийг бас гаргуулахаар бас шийдээд Засгийн газар руу оруулаад байна. Тэгэхдээ бид нар энэ жил бас яг тэжээл тариалалтын бас зохион байгуулах ажлыг бас оройтуулсан шүү. Гэхдээ маш олон газруудаас аймаг, сумдаас санал ирж, тэжээл тариалъя гэсэн санал санаачилга ирээд байгаа. Энэнд бол хөнгөлөлттэй үрийн дэмжлэгийг бол хамгийн түрүүнд олгож эхлээд байна гэдгийг бас хэлье.

Ер нь цаашидаа бол энэ газрын багц хууль Их Хурал дээр байгаа. Энэ дээр бол фермерүүдийг хажуудаа тодорхой хэмжээний газарт тэжээл тариалах газар атар газар шинээр хагалахыг бол хуульчлан заагаад өгөх нь бас зүйтэй юм. Тэгэхгүйгээр бол аливаа нэг атар хагалах хуулиар хориотой. Зөвхөн Засгийн газрын тогтоол шийдвэр гарч байж атар хагалдаг байгаа. Тэгэхээр газрын хууль дээр бас энэ асуудлыг бас тусгаж оруулах

нь зүйтэй гэсэн санал санаачилга явж байгаа гэдгийг бас хэлье.

Сүүний талаар ярилаа. Манайх бол зундаа бол ер нь сүүний хангамж 70 хувиар хангадаг. Ялангуяа шингэн сүү. Өвөл болохоор эсрэгээрээ 30 хувь болдог байгаа. Тэгээд сүүний үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, ялангуяа энэ 36 дугаар тогтоолын хүрээнд сүүний үйлдвэрлэгч компаниуд бас зээлийг авч байгаа. Тэгээд ч юу нь хүрэлцэхгүй шаардлага байна. Санхүүжилт нь хүрэлцэхгүй шаардлага байна. Ялангуяа сүүний Монгол Улсын хэмжээний 4, 5 том компаниуд бас санаачилга гаргаад сүү үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх ийм санаачилга гаргаж байгаа. Үүнийг бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол санал нэгтэй дэмжиж байгаа.

Б.Саранчимэг: Болорчулуун гишүүнд нэг минут өгье нэмж.

Х.Болорчулуун: Аливаа үйлдвэрлэл бол хийж бүтээж болно чадна тодорхой хугацаанд. Борлуулалт гэдэг чинь юунаас чухал. Тийм ч учраас Монгол Улсын Засгийн газрын Ерөнхий сайд бол бас сургуулийн үдийн цайнд нэг аяга сүү хүүхдэд өгүүлье гэсэн ийм санаачилга гаргасан байгаа. Энийг Боловсрол, шинжлэх ухааны яам манай яам 2 бол бас бүрэн дүүрэн дэмжиж хамтран ажиллахаар өнөөдөр бас хүүхдийн хоол тэжээлийн чуулган дээр бас яригдлаа гэдгийг хэлье.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн асуултаа асууя.

Ц.Идэрбат: Энэ ковид цар тахал бид бүхний бас хүнсний аюулгүй байдал хангамж ямархуу байдалтай байгаа вэ гэдгийг бас ил гаргаж ирж үнэхээр бид нар дотооддоо л юмаа үйлдвэрлэхгүй бол үнэтэй хүнс хэрэглээд явах юм байна гэдгийг бас гаргаж ирж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс энэ асуудлыг бас маш сайн бас боловсруулж гарах гарцтай хөрөнгөтэй нь ингээд шийдээд ингээд эхнээсээ үр дүн гарч эхэлж байгаа юм

байна. Энэ бол хагас жилийн үр дүн учраас бас тийм ч амлахааргүй үр дүн байна л гэж ингэж бас харж байна. Ингээд урьд өмнөх түүхүүдийг харахаар зээл яах вэ олгож байсан байна. Янз янзын хэлбэрээр. Голчлон л импортыг орлох бүтээгдэхүүн гэсэн ийм л байдлаар. Эргээд явсан явцыг нь ингээд гаргаад ирэхээр үнэхээр зориулалтын бусаар ашигласан зүйлүүд тоймгүй их байдаг юм байна. Энэ өнгөрсөн хугацаанд зарцуулсан мөнгөний чиглэл юмыг хэмжээг нь хараад чиглэлийг нь харахаар Монгол Улс өнөөдөр бол арматур, төмөр, хүнс хамаг л юмаа хангачихсан байх хэмжээнд л байж л дээ.

Тэгэхээр одоо харин энэ банкаар дамжиж байгаа 980 гаруй тэрбум төгрөгийн маань энэ зориулалтын асуудлууд дээр банк зөвхөн төлж байгаа эсэхийг хянаж байна уу, яг зориулалтын дагуу ашиглаж байна уу гэдгийг бас хянаж байна уу гэдгийг бас би нэг асуумаар байгаа юм. Энэ Монголчуудад 5 жилийн хугацаанд хэрэгжих 19 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээ өөрсдөө хангах маш том зорилт шүү дээ. Тэгэхээр энийг хэн нэгэн зальхай этгээд дундаас нь аваад зориулалт бусаар ашиглаад байвал асар их хохиролтой юм болох юм. Янз янзын эх үүсвэрээ л бүгдээрээ шавхаж байгаа учраас. Тэгэхээр энэ дээр бас яамны хувьд та бүхэн бас анхаараад өгөөрэй.

Хоёрдугаарт Болорчулуун сайдын хувьд бол энэ махны экспортын асуудал дээр харин та харин мундаг зоригтой ажиллаж байгаа. Одоо ч бас нэлээн нэмэгдэж байгаа юм байна лээ. Малчид бол энэ экспортыг өшөө нэмэгдүүлээд өгөөч ээ өшөө механизмаа хялбар болгоод өгөөч ээ Замын-Үүд дээр ганцхан компани тэгж байх ёстой юм уу эсвэл өшөө нэмэх юм уу гэсэн ийм зүйлийг сая Баянхутаг суманд явж байхад иргэн Чинзориг, Батцэцэг гэдэг хүмүүс нэлээн хурцаар тавьж байна лээ.

Тэгэхээр энэ махны экспортын асуудлаа ч гэсэн бас би нэг танаас энэ

тодорхой нэг хариулт авчихъя гэж ингэж бодож байна. Би энэ Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мал аж ахуйн газрын дарга байгаа учраас энэ хаврын энэ өвлийн хүндийг малчид ер нь арай чамай л энэ ард нь гарах гэж байна. Маш их хорогдол гарсан. Тэгээд малын индексжүүлсэн даатгал бусад даатгалын компаниуд малчны зээл зээл авахад зайлиггүй даатгуулдаг ийм систем явдаг. Тэгээд энэ болгон ер нь даатгалын үр шим гэдэг бол би ойлгохдоо цаг хүндрээд мал нь эрсдэх юм бол эргээд бас тодорхой хувийнх нь хохирлыг барагдуулах ийм л зорилготой даатгал гэж ингэж л бас ойлгодог. Тэгэхээр энэ даатгалын асуудал дээр яамны зүгээс танай газар хэлтсийн зүгээс энэ малчид руу хандсан энэ нөхцөл байдлыг харж үзэж ямархуу ажил хийхээр төлөвлөж байгаа юм байгаа юу? Байгаа бол ямар ажил төлөвлөж байгаа вэ гэж би даргаас асуух гэсэн юм.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд хариулъя.

Х.Болорчулуун: Идэрбат гишүүний хэлдгээр дотооддоо л юм үйлдвэрлэхгүй инфляц бол явагдаад л гаднын хараатаараа байна л даа. Үнэхээр Монгол Улс 70-аас 75 хувь инфляцыг гаднаас импортлож байна импортлож байгаа гэж тэгж байгаа юм. Тийм ч учраас нөгөө валютын ханиш үргэлж сар жилээр ингэж өсөөд цаашаа нэмэгдээд байдаг байхгүй юу. Тэгэхээр бид бол дотооддоо үйлдвэрлэж чадах юм болгоноо бас дотооддоо хийхийн төлөө төрийн бодлого байх ёстой. Аль ч ЗГ үндэсний үйлдвэрийг дэмжинэ гэсэн бодлого дэвшүүлдэг. Тэр нь лоозон болоод өнгөрч байсан. Харин энэ Засгийн газар бас энэ Их Хуралд 36 дугаар тогтоолыг гаргасан. Үүний дагуу бас хөнгөлөлттэй зээлийг Хүнс, хөдөө, аж ахуйн чиглэлийн компаниуд олгож байна. Нөгөө талаас зөвхөн хөнгөлөлттэй зээл олгохоос гадна хийж чадах юмаа төр хамгаалалтад авах нь юу юунаас чухал. Юу гэвэл гаднаас хийж чадаж байгаа юм нь нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаднаас орж ирж цохих дээр тодорхой хэмжээний

хязгаарлалт тогтоох. Энэ бол татварын бодлогоор хэрэгжинэ.

Тийм ч учраас 19 нэр төрөл гэж байгаа боловч задлаад 40 гаран нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо 2 жилийн дотор 2-оос 3 жилийн дотор 100 хувьд хангачих ийм боломжтой хүнсний бүтээгдэхүүнийг импортын татварыг бас хангамжтайгаа уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлэх ийм бодлогоор яамандаа санал аваад ингээд Засгийн газрын хурлаар орох гэж байгаа, хүлээгдээд байж байгаа гэдгийг бас хэлье ээ.

Ер нь бас үйлдвэрлэж чадна. Борлуулалт гэдэг чухал. Тэгэхээр үндэсний үйлдвэр дээр борлуулалтаар бас үе шатаа хангамжтай холбогдуулан дэмжих ийм бодлого явагдаж байгаа. Урьд өмнө янз бүрийн төсөл хөтөлбөрийн зээл урамшууллын зээл олгоод зүй бусаар зарцуулсан явдал бас гардаг байсан. Тийм учраас Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол манай яам бол 1 тэрбумаас дээших энэ томоохон зээлүүд дээр банкттай гурвалжин гэрээ хийж хяналт тавьж байгаа. Банкнуудаа хяналт тавьж зориулалтын дагуу ашиглаж байгаа юу үгүй юу гэдэг дээр.

Тийм учраас урьдынхтай адилхан өөр зориулалтаар хүнсний чиглэлээр хийнэ гэж авчхаад барилгын чиглэлээр оруулах ийм боломжийг бол бас хязгаарлаж байгаа гэдгийг бас хэлэх байна. Махны экспорт бол өнгөрсөн жилд 16 мянган тонн мах дөнгөж экспортод гарсан бол энэ 1 дүгээр улирлын байдлаар бараг 30 мянган тонн 29 мянган тонн мах экспортод гарсан. Тэгэхээр энэ жилийн он дуусахад ер нь бол лав л 70 мянгад хүрэх байх гэсэн ийм ерөнхий прогнозтой байгаа. Мэдээж мах экспортод гараад ирэхээр малчид баярладаг. Махны үнэ хөдөө орон нутагтаа өсдөг. Нийслэлчүүд бухимддаг. Махны үнэ өслөө гээд. Ийм 2 бас нэг хязгаар байдаг юм. Ер нь цаашидаа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бол энэ махны хангамж энэ махны худалдаа нөөцийн махыг бэлтгэхийг нь

бол нийслэлд хариуцуулахаар шилжүүлэхээр ийм бодлоготой ажиллаж байгаа нийслэл ч өөрсдөө авъя гэсэн ийм чиглэлтэй байгаа гэдгийг бас хэлье.

Экспортод хуучин бол мах гаргахдаа маш олон хоногоор бас 300-аад цаг зарцуулдаг б байгууллагаас зөвшөөрөл авдаг байдлыг халж нэг цонхны бодлогоор түргэн шуурхай 2-3 хоногт ажлын өдөрт багтааж экспортод гарах бичиг баримтаа бүрдүүлэх ийм нөхцлийг хангаж ажиллаж байгаа гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Нэмж манайхан хариулах юм байна.

Б.Саранчимэг: Нэг номерын микрофоныг өгье.

Г.Наранчулуун: Сайн байцаана уу? Идэрбат гишүүний асуултад хариулъя.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Мал аж ахуйн бодлогын хэрэгжилт зохицуулах газрын дарга Наранчулуун. Энэ жилийн өвөлжилт хаваржилт үнэхээр хүнд боллоо. Өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газрын олон улсын байгууллагууд нэлээд их хөрөнгө хүч хаяж ажиллалаа. Тухайлбал Засгийн газраас энэ өвлийн хүндрэлийг даван туулахад зориулж 7.6 тэрбум төгрөгийн асуудлыг шийдвэрлэсэн байгаа. Олон улсын байгууллагуудаас 2.1 сая ам.долларын тусламж гарсан. Харин хаваржилтын нөхцөл байдалтай холбогдуулан олон улсын байгууллагуудаас 900 мянган ам.долларын тусламж дэмжлэг үзүүлэх ажил яг хийгдэж байна. Энэ дотор хаврын энэ ажиллагаанд Хэнтий, Сүхбаатар, Дундговь гэсэн аймгууд бол нэмэгдэж орж ирсэн байгаа.

Даатгалын асуудал индексжүүлсэн даатгал гэдэг индексжүүлнэ гэдэг маань өөрөө их ярвигтай л асуудал байгаа л даа. Тэгээд манай улсад хэрэгжиж байгаа энэ

индексжүүлсэн даатгалын систем маань өөрөө олон улсын давхар даатгалд хамрагддаг. Өнөөдрийн авч байгаа борлуулалтынх нь орлогын 50 хувь нь бараг тэр олон улсын даатгалынхаа компани руу шилждэг. Тэгээд үндсэндээ 30 хувиар нь энэ үйл ажиллагааныхаа нөхөн олговрыг олгож явж байгаа явж байгаа. Тухайлбал танаас бас бичиг албан бичиг ирсэн байсан. Сүхбаатар, Хэнтий аймгуудад болсон байгалийн гамшигт үзэгдлүүдийн хүрээнд Хэнтий аймгаас 240 хэдэн сая төгрөг борлуулалтын орлого хийжээ. Энийг эргэн нөхөн төлүүлэхэд нь анхаарч үзнэ үү гэсэн бичиг орж ирж байсан. Бид бол энийг бас судалж үзсэн байгаа.

Тэгэхээр 2022 онд даатгуулсан иргэд 2023 оны хагас жилийн мал тооллогын дараа иргэн нөхөн төлбөр авахаар байгаа. Урьдчилсан тооцоогоор харах юм бол хэдий 200 хэдэн сая төгрөг төлсөн ч гэсэн Хэнтий аймаг гэхэд эргэн нөхөн олговор дээр 60-аас 70 сая төгрөгийн л нөхөн олговор авахаар байгаа.

Тэгэхээр энэ босго үзүүлэлт 5 хувь, 6 хувь тэгээд тэрнээс илүү гарсанд нь нөхөн олговор олгодог энэ тэр гэдгийг бол бас тэр бүүр хүмүүс сайн ойлгодоггүй. Нэгд яг л зээл авахдаа юм уу улсын аварга малчин болох хөшүүргээр л энэ даатгалд хамрагдаж байна. Өнөөдөр яг эрсдэлээ тооцож энэ даатгалд хамрагдахгүй байгаа учраас тийм сайн бас явахгүй байгаа, нэгдүгээрт.

Хоёрдугаарт энд индексжүүлсэн даатгал компани маань өөрөө Сангийн яамны харьяа байгууллага байгаа манай яамны зүгээс яадаг вэ гэхээр малчдад сурталчилгаа хийх хамтран ажиллах багийн Засаг дарга нарын дунд аль хэн сайн сурталчилж чадсанд нь уралдаан зарлах ч гэдэг юм уу иймэрхүү маягаар л хамтарч ажиллаж байгаа. Тэрнээс бид нар босго үзүүлэлтийг нь доош нь буулгах санал хэчнээн хэд хэдэн удаа тавьж байсан. Үнэндээ бас энэ нь цаанаа болдоггүй л юм шиг байна лээ.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Болорчулуун сайд бол бүр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд. Энэ яамны дотор яг Мал аж ахуйн бодлогыг барьж байгаа нь та шүү дээ. Тэгээд таны хариулт тийм юм шиг байна лээ. Зүгээр юу гэдэг юм сурталчилж ажилласан. Малчдын эрх ашгийг хамгаалах тал дээр бас юу хийж байгаа юм? Тэгвэл тэр бас таны ажлын нэг хэсэг биз дээ? Тэр 50 хувь нь гадагшаа явчихдаг даатгалыг та нар сурталчилж ажилласан юм уу? Гадагшаа явдгийг нь мэдсэн юм бол тэгвэл өөр хариу арга хэмжээ авах даатгалыг тэгвэл зөв талаас нь ойлгуулах тийм зүйлүүдийг яагаад хийдэггүй юм?

Тэгээд ниргэсний хойно хаширав гэдэг шиг л юм ярьж байна. Гэхдээ ниргэхийнх нь өмнө та нарыг аварна гэж тэгээд л та нарын сурталчилсан тэр юм чинь өнөөдөр тэгвэл тэгээд худлаа байсан юм уу? Энэн дээр та бас энэ бодлого.

Б.Саранчимэг: Идэрбат гишүүн бас их чухал асуултуудыг хөндөж асуулаа.

Тэгэхээр Монгол Улсын Ерөнхийлөгч хүнсний хангамж, хүнсний аюулгүй байдлын тал дээр маш том санаачилга гаргаад өнөөдөр бас Улсын Их Хурал дээр хэлэлцээд 36 дугаар тогтоолыг баталсан. Тэгэхээр Улсын Их Хурал бол хийх ажлаа гол ажлаа хийчихсэн. Өнөөдөр бид нар гол шаардаж байгаа зүйл бол энэ 36 дугаар тогтоолтой холбоотой орж ирэх ялангуяа Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас орж ирэх энэ хуулиуд хүлээгдээд байгаа. Өнөөдөр яг нэг жил болж байна. Энэ тогтоолыг баталснаас хойш. Тэгээд энэ хугацаанд энэ хууль орж ирээгүй байна аа. Нэг орж ирсэн хуулиа зохицуулах үйлчлэлтэй Хүнсний тухай хуулийг татаж авна гэсэн татаж авсан нь тодорхойгүй.

Өнөөдөр ямар ч хууль орж ирээгүй энэ цаг хугацаа чинь өнгөрөөд байдаг. Хэдий Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтийн үеэр ч гэсэн яам ажиллаж л байсан. Энэ дээр шүүмжлэлтэй хандаж байна. Энийг хурдан яаралтай оруулж ир ээ. Хэзээ яг хэзээ оруулж ирэх гэж байна. Хэзээ энэ хуулиа татаж эсвэл энийгээ хэлэлцүүлэх юм уу гэдэг дээр нэг асуулт байна. Нөгөө нэг асуулт бол бид нар хүнсний аюулгүй байдал хүнсний хангамж гээд ирэхээр яах аргагүй энэ бэлчээртэй холбоотой юм.

Өнөөдөр бэлчээрийн асуудал ямар байгаад байгаа билээ. Өнөөдөр дараагийн 10 жилд өнөөдөр бэлчээр чинь байх уу үгүй юү гэдгийг манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бодлогоо тодорхойлж байгаа. Энэ дээр дахиад энэ байдлаараа явна гээд тэгэх юм бол үнэхээр бэлчээргүй болчихсон байна гэдгийг бас маш олон судлаачид Монголд төдийгүй энэ гадаадын судлаачид гаргаад ирчихсэн байна шүү дээ.

Тэгэхээр яг л одоо шинэ бодлого гаргаж ирэхгүй яг л энэ байдлаараа байна гэдэг энэ асуудлыг яам бариад байгаа нь үнэхээр эмгэнэлтэй.

Тийм учраас Тогтохсүрэн гишүүн бүхий энэ гишүүд яг энэ газрын хууль оруулаад тусдаа Бэлчээрийн тухай хуулийг оруулж ирж байгаа. Эрдэмтэн судлаачдын баг ажиллуулж байгаа. Энэ дээр гэрээний асуудал энэ хуультай та бүхэнд бас танилцуулагдсан байгаа. Энэ дээр ямар санаа оноотой байгаа вэ гэсэн нэг асуулт. Нөгөө нэг асуулт боо одоо энэ үдийн хоол өнөөдөр анх удаагаа бас үндэсний том чуулган болоод бас төр засгаас илүү их анхааралдаа авч байна. Тэгээд түүрүүний парламентын гишүүн байж байхдаа миний бие бас санаачилсан гишүүний нэгийн хувьд үдийн цайг үдийн хоол болгосон.

Өнөөдөр үдийн хоол өнөөдөр хүүхдэд өгч байгаа үр шим нь ямар байна. Судалгаан дээр хүүхдүүдийн кальци ямар дутагдалтай байгаа билээ. Сая Дундговьд

баг очиж ажиллаад цэцэрлэг сургуулиудын тогооч нарын дунд тэмцээн зохион байгуулаад Койкагийн судалгаан дээр үндэслээд өнөөдөр хүүхдүүдийн кальци үнэхээр дутагдалтай байна гээд тэгсэн. Тэгээд яг газар дээр нь очоод үзэхээр өнөөдөр сургууль, цэцэрлэгийн махны, сүүний хангамж үнэхээр бас тэр нь бэлэн биш байгаад байна.

Тэгэхээр 1 хүүхдэд нэг аяга сүү гээд өнөөдөр Монгол Улсын Ерөнхий сайд бас санаачлаад энийг ажил хэрэг болгоно гээд ингээд яам тэгж байдаг. Яг өнөөдөр газар дээрээ энэ бүтэх үү. Үнэхээр энэ боломж нь бүрдчихсэн байгаа юу? Энэ дээр нэг тодорхой асуултаа асууя. Нөгөө талаар бид нарын 2023 оны төсөв дээр 223 тэрбум төгрөг бас танай яаман дээр бас батлагдчихсан байгаа. Энэ хэрэгжилт нь ямар байгаа вэ? 36 дугаар тогтоолын хэрэгжилтийг та бүгд бас гаргаж ирж байна. Гэхдээ бид нар бол хууль эрх зүйн орчноо сайжруулах дээр та бүгдээс шаардана энийгээ яаралтай оруулж ир ээ, яг хэзээ оруулж ирэх гэж байгаа вэ гэсэн ийм нэг асуулт байна.

2 номерын микрофоныг өгье.

Ц.Болорчулуун: Саранчимэг гишүүний асуултад хариулъя.

Бодлого төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун. Тэгэхээр хүнсний хангамж, аюулгүй байдал, үндэсний хөдөлгөөн, түүнийг хэрэгжүүлэх Улсын Их Хурлын 36 дугаар тогтоол дээр хууль, эрх зүйн орчин гэдэг бол үндсэн 5 зорилтын нэг зорилт болж орсон. Энэ зорилтын хүрээнд 8 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ийм зохицуулалтыг оруулсан байгаа. Үүнээс бид яг зарим хуулиуд дээр 1-2 ийм заалтууд, өөрчлөлтүүд орж байгаа учраас Мал аж ахуйн салбарын хуулиа бол цогцоор нь одоо нэг хуулийн багц хууль болгоод ингээд Засгийн газарт оруулаад өргөн барих түвшинд оччихсон байж байгаа. Тэгэхээр бид нар энэ 8 хуулиас үндсэндээ 4 хуульд нь ингээд өөрчлөлт оруулчхаж байна гэсэн үг. Бусад 4 хууль дээрээ бол ажлын

хэсгүүд гараад ажиллаад мэдээж хууль боловсруулах гэдэг бол өөрөө бас цаг хугацааны тооцоо судалгаа, тандан судалгаанууд, үр ашгийн тооцоонууд, эдийн засгийн судалгаанууд хийгддэг учраас энэ ажлууд хийгдээд ажлын хэсгийн түвшинд ерөнхийдөө боогдоод дуусаж байгаа. Одоо бид нар чадвал одоо энэ хаврын чуулганаар оруулах гээд ингээд бэлтгэл ажлуудаа хангаад ажиллаж байна. Мэдээж хуулийг оруулахад бас хэд хэдэн удаагийн олон нийтийн хэлэлцүүлгүүд хийх ёстой. Энэ хэлэлцүүлгүүдийг ингээд зохион байгуулаад үндсэндээ яг 36-тай холбоотой хууль, эрх зүйн орчнуудыг энэ жилдээ багтаагаад энэ хуулиа өргөн бариад батлуулаад оруулна гэсэн. Өргөн мэдүүлээд батлуулна гэсэн ийм чиглэлтэйгээр ажиллаж байгаа.

Тэгэхээр энэ дээр бол энэ хууль эрх зүй гэсэн энэ зорилтын хүрээнд нэлээд бас ахиц дэвшилттэй явж байгаа гэж ингэж ойлгож байгаа. Мал аж ахуйн салбарын талаар үнэхээр бас бодлогын асуудлууд бас хоцрогдолтой байгаа. Тухайлах юм бол Монгол мал арга хэмжээ үндэсний ийм арга хэмжээ хөтөлбөр орон даяар хэрэгжсэн. Дараа нь Монгол малчин хөтөлбөр хэрэглээд ингээд Засгийн газрын тогтоолоор энэ хөтөлбөр ингээд хэрэгжилтийнхээ үр дүнгийн тайланг гаргаад дуусаж байгаа. Одоо яаман дээр ямар арга хэмжээ явж байна вэ гэхээр мал аж ахуйн салбарын стратеги төлөвлөгөөг боловсруулах ийм ажлын хэсэг байгуулагдаад тал талын оролцоотойгоор энэ ажлын хэсэг ерөнхийдөө энэ Мал аж ахуйн салбарын стратеги төлөвлөгөөг боловсруулаад гаргаад ирсэн байж байгаа. Одоо бид нар сая бас холбогдох судалгааны байгууллагатай хамтраад малчдын фокус судалгааг зохион байгуулсан.

Энэ судалгааны үр дүнгээ танилцаад энэ Мал аж ахуйн стратеги төлөвлөгөө дээрээ энэ малчдынхаа нийгмийн асуудал бусад энэ эрчимжсэн Мал аж ахуйн чиглэлийн малчдад малчдын санхүүжилтийн асуудал, тэгээд залуу

малчин, залуу боловсон хүчний асуудал гээд ингээд олон асуудлуудыг тусгасан ийм цогц төлөвлөгөө боловсруулж байгаа.

Энэ төлөвлөгөөгөөрөө бол бид нар Их Хуралд оруулах уу, Засгийн газарт оруулах уу гэдэг шийдвэрийг нь гаргаад хэлэлцүүлгээ хийгээд энэ малчдын фокус судалгаатайгаа нэгтгээд 1 цогц арга хэмжээг шийдүүлэхээр ингээд төлөвлөөд ажиллаж байна. Энэ бол бас яаман дээр нэлээд гараад ирчихсэн. Одоо бол хэлэлцүүлэг хийх шат руугаа ингээд орж байгаа. Ийм асуудал байгаа. Энэ дээрээ бол Мал аж ахуйн салбарынхаа бодлогуудыг ойрын 5 жилд хэрэгжүүлэх энэ бодлогуудаа бүгдийг нь багцаар нь судалж оруулж байгаа. Тэгэхээр энүүгээр бол олон асуудлууд шийдэгдэнэ ээ гэж ингэж тооцоолж үзэж байгаа.

Б.Саранчимэг: Болорчулуун сайд нэмж хариулах уу? Саяын миний асуулт дээр.

Саранчимэг гишүүн тэр сүүний хангамжийн талаар асуусан. Тэгэхдээ үйлдвэрлэл гэдэг бол гэнэтхэн сарын дотор ч юм уу жилийн дотор огцом өсөх ийм боломж байхгүй. Гэхдээ ялангуяа тэр Ерөнхий сайдын нэг хүүхдэд өдөр болгон нэг аяга сүү гэсэн ийм санаачилгыг бид нар хэрэгжүүлэхийн төлөө бүх л боломж бололцоогоо ашиглан ажиллана. Бас сүүний томоохон компаниудаас бас санал санаачилга гаргаж бас яамтайгаа хамтран үйлдвэрлэлээ өргөтгөх богино хугацаанд өргөтгөх ийм төсөл төлөвлөгөө гаргаж бас ажиллаж байгаа. Хангамж бол шингэн сүү зундаа 70 хувь, өвөлдөө 30 хувь байдаг.

Б.Саранчимэг: Яг хөдөө орон нутагт ингээд газар дээр нь очоод ажиллахаар бид бас тодруулмаар байна. Тэгээд хөдөө орон нутагт газар дээр нь очоод ажиллахаар өнөөдөр энэ хангамжийн тогтолцоо чинь байхгүй болчихсон байна. Тэгэхээр өнөөдөр хүүхдийн эрүүл мэнд гэдэг нийгмийн эрүүл мэндийн асуудал бүүр цаашилбал үндэсний аюулгүй байдлын асуудал

хүүхдийн өсөлт чинь яах аргагүй энэ кальцитай холбоотой байгаа энэ үед Койкагийн хийсэн судалгаа хүүхэд болгон л бараг кальцийн дутагдалтай байна гээд ийм судалгаа гарчихсан.

Тэгэхээр бид нар өнөөдөр ярих биш яг орон нутаг дээр чинь энэ ямар нэгэн үйлдвэр жишээ нь сая Дундговь дээр очоод ажиллаж байхад ямар ч сүүний тийм хангамжийн асуудал дээрээс нь махны хангамжийн асуудал нөгөө үдийн хоолны асуудал чинь үнэхээр дутагдалтай байна. Тэгэхээр энэ чинь ганц Дундговь биш гэдгийг өнөөдрийн бас энэ үдийн хоолон дээр ба болж байгаа чуулган хэлж байгаа учраас та бүгд маань яг энэ хангамжийн асуудлыг цогцоор нь бас яг энэ хүүхдийн үдийн хоолны асуудлыг бүүр цогцоор нь бас энэ Засгийн газрынхаа хэмжээнд хамтарч ажиллах хэрэгтэй байна шүү.

Тэгээд Боловсролын яаман дээрээ хамтарч анхаарч ажиллаж байна. Манай Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам бас хамтарч ажиллах хэрэгтэй байна. Тэгээд ер нь бол энэ эрүүл хүүхэд эрүүл хүн байлгахын тулд бас ийм эрүүл хөрс жишээ нь малчин бэлчээрийн алдагдлаас бэлчээрийн үнэхээр доройтлоос болоод нөгөө малын идэж байгаа бэлчээр нь үнэхээр чанаргүй болоод ирчихсэн үед ч гэсэн өгч байгаа

өгөөж чинь ч гэсэн чанаргүй байгаа энэ цаг үед манай энэ Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хөдөө аж ахуй тал дээрээ илүү сайн бодлого гаргах хэрэгтэй байгааг бас онцолж хэлэхийг хүсэж байна.

Тэгээд ямар ч байсан энэ 36 дугаар тогтоол чинь батлагдаад жил болчихлоо. Энэ хавартаа өргөн барь. Тэр зохицуулах үйлчлэлтэй Хүнсний тухай хуулийг танай яам өөрсдөө өргөн барьсан. Эргээд энийгээ дахиад татна гээд ингээд байдаг. Тэгээд яриад байдаг. Өнөөдөр бид нар жил болчихсон энэ цаг үед бас нэг дэвшилттэй явж байгаа гэж ярих биш та нар өргөн барих цаг чинь болчихсон шүү. Их Хурал энэ тал дээр 36 дугаар тогтоолынхоо хувьд ажлаа хийчихсэн. Тэгэхээр яамыг энэ дээр хурдан хууль эрх зүйн орчноо сайжруулах хуулиудаа өргөн барихыг бас шаардаж байна. Тэгээд өнөөдрийн хуралд бас асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд байна уу? Алга байна. Өнөөдрийн энэ хуралд хүрэлцэн ирсэн ажлын хэсэг болон Улсын Их Хурлын эрхэм гишүүддээ баярлалаа. Хурал дууслаа.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ
П.МЯДАГМАА